Bluebook 2021

Цахилгаан автомашины эрин эхэлж байна

Та бэлэн үү?

Агуулга

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ТЕСЛАГИЙН ХУВЬЦААГ АВЧ АМЖСАН УУ? ҮГҮЙ БОЛ ДАРААГИЙН БОЛОМЖИЙГ БҮҮ АЛД

- Дэлхийн автомашины зах зээлийн динамик
- Цахилгаан автомашины зах зээлийн динамик
- БНХАУ-ын цахилгаан автомашины зах зээлийн нөөц
- Дүгнэлт

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

- Монгол Улсын 2021 оны эдийн засгийг зэс, нүүрсний экспорт бүрдүүлнэ
- Уул уурхайн салбар сэргэнэ
- 2021 онд эдийн засаг 4 орчим хувиар өсөх төлөвтэй байна
- Ханш тогтвортой байх хүлээлттэй байна

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

МОНГОЛЫН БОЛОН ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2021 ОНЫ ТӨЛӨВ

- Монголд бондын зах зээл хөгжих алтан үе ирээд байна
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хөрөнгө оруулах боломж нээгдээд байна
- Хувьцааны зах зээлд шинэ давлагаа үүслээ
- Банкны реформ нь санхүүгийн зах зээлийн олон тулгуурт хөгжлийн үндсийг тавилаа

БИД ТАНД ЮУ ӨГЧ ЧАДАХ ВЭ?

- Брокерийн үйлчилгээ
- Арилжаа, судалгаа
- Андеррайтерийн үйлчилгээ
- GCC академи

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

О.Мөнхжаргал
Гүйцэтгэх захирал,
Голомт Капитал ҮЦК ХХК

ЭРХЭМ ХҮНДЭТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА

Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд шинэ соёлыг түгээхээр зорин ажиллаж буй Голомт Капитал ҮЦК ХХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд андеррайтер, брокер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг гадаад дотоодын харилцагч, түнш, хамтран ажиллагч байгууллагууддаа хүргэж ирсэн.

2020 онд дэлхий нийтийг цочроосон коронавирусын цар тахал дэгдэж, эдийн засаг бүхэлдээ саармагжин, хөрөнгийн зах зээлд тодорхойгүй нөхцөл байдал, ханшийн савлагаа үүссэн жил тохиолоо. Мөн Монголд төрийн эрх барих дээд байгууллагаас зээлийн хүүг бууруулах шат дараалсан арга хэмжээг авснаар төгрөг болон долларын хадгаламжийн хүү буурч харилцагчдад очих санхүүгийн өгөөж багасаж байна.

Тиймээс бид дээрх бэрхшээлүүдийг харилцагчдынхаа хамтаар боломж болгохоор зорин, үнэ цэн нь улам бүр өсөх баялгийг эзэмшихэд нь туслах, хойч үедээ өвлүүлэн үлдээх нөхцөлийг бүрдүүлэхээр шийдсэн билээ.
Нэн тэргүүнд бид, харилцагчдынхаа хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг мэдээллийг тэлэх, ухаалаг хөрөнгө оруулагчдыг бэлтгэх зорилгоор GCC академийг үүсгэн байгууллаа.

Ингэснээр салбарын шилдэг судлаач, шинжээчдээс бүрдсэн сургагч багш нар, хөрөнгийн зах зээлийн анхан болон дунд шатны мэдлэгийг олгох цуврал хичээл, олон улсын хөрөнгийн зах зээлийн ханшийн мэдээлэл, долоо хоног бүрийн эдийн засаг, таваарын зах зээл болон онцлох салбар, компаниудын талаарх судалгааг харилцагчдадаа тогтмол хүргэж, ухаалаг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад нь туслан ажиллаж байна.

Мөн харилцагчдадаа дэлхийн хөрөнгийн биржүүдийн арилжаанд оролцох мэдлэг, дадлагыг олгох зорилгоор Interactive Brokers демо арилжааны уралдааныг зарлаж, суурь болон техник шинжилгээг хэрхэн хийх, ямар

стратегийг баримтлах зэрэг онол, практикийг хослуулсан сургалтыг тогтмол явуулж ирлээ.

Бидний Монгол Улсад анх удаа цогцоор нь нэвтрүүлсэн Interactive Brokers үйлчилгээ нь харилцагч тив дэлхийн хаана ч байсан хүссэн цагтаа (24/7) гадаадын хөрөнгийн биржүүдийн арилжаанд оролцож, хувьцаа, бонд, үнэт метал зэрэг бүтээгдэхүүнээс сонголтоо хийх зэрэг үйлчилгээг гар утас, компьютерээ ашиглан авах боломжийг олгосон юм.

Голомт Капитал ҮЦК ХХК нь 2020 онд хөрөнгийн зах зээлээр дамжуулан баялгийн тэгш хуваарилалтыг түгээх зорилгыг үйл ажиллагааныхаа бүхий л чиглэлд баримтлан ажилласнаар, Монголчууд үндэсний үйлдвэрлэгч компаниудын зөвхөн хэрэглэгч нь биш хөрөнгө оруулагч нь болж байна. 2019 онд бид Түмэн Шувуут, Монос Хүнс ХК-ийн IPO-г амжилттай хэрэгжүүлэн, нийт 18,585,858,960 төгрөгийг татан төвлөрүүлж, Монголын хөрөнгийн биржийн анхдагч арилжааны 36 хувийг дангаар эзэлж байсан бол 2020 онд Монголын анхны хайбрид бонд болох Мастер түншлэлийн бонд болон анхны банкны баталгаат Нөмөр бондыг хаалттай хүрээнд амжилттай хэрэгжүүлсэн юм.

Монголын хөрөнгийн зах зээл сонгодог хөгжлийн замдаа хараахан ороогүй байна. Тиймээс тус салбарыг дэлхийн жишигт нийцүүлэн хөгжүүлэх түүхэн хариуцлага бидний өмнө тулгарч буй тул бид харилцагчдадаа дэлхийн түвшинд нийцсэн үйлчилгээг үзүүлэхээр хичээнгүйлэн ажиллаж байна.

Олон улсад иргэд өөрсдийн тэтгэврийн хуримтлалынхаа тодорхой хэсгийг хөрөнгө оруулалтын санд оруулж, тус сангийн мэргэжилтнүүд энэхүү хөрөнгийг өндөр үр дүнтэйгээр удирддаг. Ингэснээр иргэд төлсөн шимтгэлийнхээ тодорхой хувиар ашигтай бизнесүүдийн хувьцааг авч, өндөр өгөөж хүртэн, санхүүгээ арвижуулдаг билээ. Нөгөө талд үндэсний хэмжээний томоохон компаниуд хөрөнгө оруулалтын хямд эх үүсвэртэй болж, улмаар банк болон хөрөнгийн зах зээлийн үзүүлэлт тэнцвэрждэг юм.

Тийм ч учраас бид Монгол Улсад хөрөнгө оруулалтын сан байгуулахаар зорин, тэтгэврийн шинэчлэлийн хууль боловсруулах ажлын хэсэгт орон ажиллаж байгаагаа дуулгахад таатай байна.

Ингээд эрхэм хүндэт харилцагч танд бидэнд ямагт өндөр итгэл хүлээлгэн, хамтран ажиллаж ирсэнд гүн талархал илэрхийлье.

Эрхэм таны ажил үйлс тэгш дүүрэн байж, хөрөнгө оруулалтын шийдвэр тань мэргэн байхыг хүсэн ерөөе!

ХҮНДЭТГЭСЭН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
О.МӨНХЖАРГАЛ

ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ТЕСЛАГИЙН ХУВЬЦААГ АВЧ АМЖСАН УУ? ҮГҮЙ БОЛ ДАРААГИЙН БОЛОМЖИЙГ БҮҮ АЛД

Т.Азтүшиг
Стратеги шинжээч,
aztushig@golomtcapital.com

Хүн төрөлхтөн XX зуунд анхны автомашиныг бүтээснээс хойш эдүгээ хүн бүр хэдэн зуун морины хүчтэй төмөр хүлэг хөлөглөх болжээ. Энэхүү үсрэнгүй хөгжлийн үр дүнд Японы Toyota, Германы Volkswagen, Mercedes Benz, BMW, Өмнөд Солонгосын Hyundai, АНУ-ын General Motors, Ford зэрэг брэндүүд үүсэж, чанар аюулгүй баталгаат байдлаараа өрсөлдөж байна. 2000 оноос хойш эдгээр компаниудын хувьцааны ханш 100-1200 хувиар өсчээ. Гэхдээ дээрх брэндүүд нь бүгд дотоод шаталтат хөдөлгүүртэй автомашин үйлдвэрлэдэг тул заавал хүн жолоодох шаардлагатай байдаг.

Харин XXI зууны техник технологийн хөгжил бидний мэдэх энэхүү ойлголтыг орвонгоор нь эргүүллээ. Учир нь сүүлийн арав гаруй жилийн хугацаанд цахилгаан автомашины хөгжүүлэлт эрчээ авснаар, тус салбарт манлайлагч Тесла компанийн зах зээлийн үнэлгээ л гэхэд 2020 оны 12 дугаар сард 650 тэрбум ам.долларыг даваад байна.

Энэ нь дэлхийн автомашин үйлдвэрлэгч хамгийн том есөн компани болох Toyota, Volkswagen, Nissan, Hyundai, General Motors, Ford, Honda, Fiat Crysler, Peugeot нарын үнэлгээг нийлүүлсэнтэй тэнцэж байгаа юм.

Тэгвэл Теслагийн амжилтыг цаашид хэн залгамжлах бол? Тэдэнд хөрөнгө оруулбал хэдий хугацаанд, хэр их өгөөж хүртэх бол?

ДЭЛХИЙН АВТОМАШИНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ДИНАМИК

2008 онд дэлхийн хэмжээнд нийт 53.16 сая автомашин үйлдвэрлэж байсан бол 2008-2019 онд энэ үзүүлэлт 40 хувиар өсөж, 74.64 сая болсон байна.

Дэлхийн автомашины үйлдвэрлэл /сая ширхэг/



Эх сурвалж: Bloomberg terminal

2008-2019 он хүртэл бүс нутгуудад төвлөрч байсан автомашины үйлдвэрлэлийн салбарт томоохон өөрчлөлт гарч Ази тив рүү шилжсэн юм. Энэ хугацаанд Азийн автомашин үйлдвэрлэлд эзлэх хувь 38 хувиас 48 хувь болж өсчээ.

Автомашины үйлдвэрлэл бүс нутгаар /2008 он/



Эх сурвалж: Bloomberg terminal

Автомашины үйлдвэрлэл бүс нутгаар /2019 он/



Эх сурвалж: Bloomberg terminal

Нийт борлуулалтад эзлэх цахилгаан авто машин



Эх сурвалж: Bloomberg terminal

Автомашин үйлдвэрлэлийн салбарт маш их анхаарал татаж буй нэгэн үзүүлэлт бол 2010 оноос хойш автомашины борлуулалтад цахилгаан автомашины эзлэх хувь өссөн явдал юм.

2010 онд нэг бүхэл хувьд хүрдэггүй байсан энэ үзүүлэлт 2019 онд 5.91 хувь болж өсчээ.

2008 оны байдлаар Ази номхон далайн бүс нутгийн орнуудад нийт 20.05 сая ширхэг автомашин үйлдвэрлэж байжээ. Харин 2008-2019 онд энэ үзүүлэлт 79 хувиар өсөж, 2019 онд 35.95 сая автомашин үйлдвэрлэсэн байна.

Азийн автомашины үйлдвэрлэл /сая ширхэг/



Эх сурвалж: Bloomberg terminal

Анхаарал татаж буй гол үзүүлэлт бол БНХАУ нь нийт автомашин үйлдвэрлэлийн 72 хувь буюу 25.75 сая дангаар үйлдвэрлэж буй нь иргэдийн худалдан авах чадвар нэмэгдэж, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн чанар сайжирсантай холбоотой юм.

Азийн автомашины үйлдвэрлэл улсаар /2008 он/



Эх сурвалж: Bloomberg terminal

Азийн автомашины үйлдвэрлэл улсаар /2019 он/



Эх сурвалж: Bloomberg terminal

ЦАХИЛГААН АВТОМАШИНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ДИНАМИК

Цахилгаан автомашины үйлдвэрлэл улсаар /сая ширхэг/



Эх сурвалж: Bloomberg terminal

Дэлхийн улс орнууд 2010 оноос эхлэн цахилгаан автомашины үйлдвэрлэлд анхаарлаа хандуулж эхэлсэн бөгөөд тухайн үед 17,000 гаруй цахилгаан автомашин үйлдвэрлэгдэж байв.

Харин 2019 онд энэ тоо 7.2 саяд хүрсэн бөгөөд нийт цахилгаан автомашины 47 хувийг БНХАУ-д ашиглаж байна.

Графикт харуулснаар 2019 оны байдлаар, БНХАУ цахилгаан автомашины үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлж байгаа бол түүний дараа Япон болон АНУ орж байна.

Цахилгаан автомашины үйлдвэрлэл улсаар /2016 он/



Эх сурвалж: Bloomberg terminal

Цахилгаан автомашины үйлдвэрлэл улсаар /2019 он/



Эх сурвалж: Bloomberg terminal

Дэлхийн улс орнууд цаг уурын өөрчлөлт, агаарын бохирдолтой тэмцэхийн тулд хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах олон талт арга хэмжээг авч байна.

2019 оны байдлаар БНХАУ нь дэлхийн хэмжээн дэх CO2 -ын ялгаруулалтын 30.3 хувийг дангаар бүрдүүлж байгаа бол АНУ 13.4 хувиар удаалж байна.

Д/д	Улс	CO2 ялгаруулалтын хэмжээ	Эзлэх хувь
1	БНХАУ	11.5	30.3%
2	АНУ	5.1	13.4%
3	Энэтхэг	2.5	6.6%
4	ОХУ	1.7	4.5%
5	Япон	1.1	2.9%
6	Герман	0.7	1.8%
7	Иран	0.7	1.8%
8	Өмнөд Солонгос	0.7	1.7%
9	Канад	0.6	1.6%
10	Бусад	13.4	35.3%

Эх сурвалж: EDGAR Emmission Database for Global Atmospheric Research

Дэлхийн улс орнууд агаарын бохирдлыг бууруулахын тулд олон талт арга хэмжээ авч буйн илэрхийлэл нь цахилгаан автомашины хэрэглээг дэмжиж, амьдралд эрчимтэй нэвтрүүлэх зорилт юм.

Улс	Зорилтот автомашины төрөл	Зорилтот он	Зорилт	Эх сурвалж
БНХАУ	Автомашин	2025	25% цахилгаан автомашин	Засгийн газрын тогтоол
Япон	Суудлын автомашин	2030	23%-33% цахилгаан автомашин	Засгийн газрын тогтоол
Энэтхэг	Суудлын автомашин	2030	30% цахилгаан автомашин	Зам тээврийн яамны сайд
Герман	Суудлын автомашин	2050	100% цахилгаан автомашин	ZEV холбоо
Франц	Суудлын автомашин	2040	Шаталтат түлш хэрэглэдэг автомашингүй болох	Үндсэн хууль
Канад	Автомашин	2040	100% цахилгаан автомашин	Засгийн газрын бичиг баримт
Англи	Суудлын автомашин	2035	бензин, диезэл, хайбрид, плаг ин хайбрид машингүй	Ерөнхий сайд
Швед	Суудлын автомашин	2030	бензин, диезэл машингүй болох	Засгийн газрын тогтоол

Эх сурвалж: International council on clean transportation

БНХАУ-ЫН ЦАХИЛГААН АВТОМАШИНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НӨӨЦ

Т.Азтүшиг
Стратеги шинжээч,
aztushig@golomtcapital.com

БНХАУ нь агаарын бохирдлыг бууруулах чиглэлд онцгой анхааран ажиллаж байна.

Тодруулбал:

- Эдүгээ тус улсын агаарын бохирдол 11 gt байгаа бөгөөд 2030 он гэхэд 60-65 хувиар бууруулах зорилтыг тавьснаа Paris Climate Agreement & Rainforest Conservation-ийн үеэр мэдэгдсэн юм.
- НҮБ-ын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн чуулга уулзалтын үеэр БНХАУ-ын ерөнхийлөгч Ши Жинпинь 2060 онд агаарын бохирдлыг бүрэн арилгахаар зорьж байгаагаа зарласан юм.

Тус улс дээрх зорилтдоо хүрэхийн тулд цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна. Тодруулбал, 2019 онд нийт автомашины борлуулалтын 5.3 хувийг цахилгаан автомашин эзэлж байгаа бол 2050 он гэхэд 100 хувьд хүргэхээр зорьж байна.

БНХАУ-ын автомашины борлуулалтад эзэлж буй цахилгаан автомашины борлуулалтыг өсгөх бодлого



Эх сурвалж: Climate action tracker

БНХАУ нь 2010 оноос хойш цахилгаан автомашины үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг баримталж эхэлсэн бөгөөд хамгийн сүүлд 2020 оны 4 дүгээр сарын 23-нд 6 дахь удаагаа шинэчлэн батлахдаа хугацааг нь 2022 он хүртэл сунгасан байна.

Ингэснээр дараах шаардлагыг хангасан цахилгаан автомашин үйлдвэрлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа юм.

Автомашины төрөл	Технологи	Он	Тухайн онд тавигдаж байсан шаардлага		Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг /CNY/
			Нэг цэнэглэлтээр явах замын хэмжээ /км/	Автомашины үнэ татвар оруулсан дүн /CNY/	
Суудлын автомашин	BEV	2019	≥250	-	300км<Туулах зам<400км бол 18,000CNY Туулах зам>400км бол 25,000CNY
		2020	≥300	300,000	300км<Туулах зам<400км бол 16,200CNY Туулах зам>400км бол 22,500CNY
	PHEV	2019	≥50	-	10,000CNY
		2020		300,000	8,500CNY
Автобус	BEV	2019	≥200		300км<Туулах зам<400км бол 18,000CNY Туулах зам>400км бол 25,000CNY
		2020			300км<Туулах зам<400км бол 16,200CNY Туулах зам>400км бол 22,500CNY
	PHEV	2019	≥50	-	10,000CNY
		2020			8,500CNY
Ачааны машин	BEV	2019	≥80	-	300км<Туулах зам<400км бол 18,000CNY Туулах зам>400км бол 25,000CNY
		2020			300км<Туулах зам<400км бол 16,200CNY Туулах зам>400км бол 22,500CNY
	PHEV	2019	≥50	-	10,000CNY
		2020			8,500CNY

Эх сурвалж:International council on clean transportation

БНХАУ-д 2020 онд хамгийн их борлогдсон цахилгаан автомашин Теслагийн "Модель 3" загвар

BEV гэж юу вэ?

BEV /Battery electric vehicle/ буюу цахилгаан тэжээлт автомашин нь дотоод шаталтат хөдөлгүүргүй зөвхөн цахилгаанаар цэнэглэж тэжээлээ авдаг. БНХАУ-ын төрөөс дэмжлэг авахын тулд суудлын цахилгаан автомашин нь нэг удаагийн цэнэглэлтээрээ 300 км-ээс дээш замыг туулах чадвартай байх шаардлагатай.

БНХАУ-д 2020 онд хамгийн их борлогдсон цахилгаан автомашин загвар

2019 оны байдлаар дэлхийн хэмжээнд цахилгаан автомашины удаан цэнэглэгч 598 мянга, хурдан цэнэглэгч 264 мянга байна.

Цэнэглэгч удаан/598 мянган цэнэглэгч/

Эх сурвалж: International energy agency

Цэнэглэгч хурдан/264 мянган цэнэглэгч/



Эх сурвалж: International energy agency

Үүнээс БНХАУ-д нийт удаан цэнэглэгчийн 52 хувь буюу 310 мянган цэнэглэгч байгаа бол хурдан цэнэглэгчийн 82 хувь буюу 216 мянган цэнэглэгч ашиглагдаж байна. Аж үйлдвэрлэл өндөр хөгжсөн орны хувьд цаашид уг дэд бүтцийг хөгжүүлэхэд ямар нэгэн асуудал тулгарахгүй юм.

БНХАУ-д 2020 онд хамгийн их борлогдсон цахилгаан автомашин Guangzhou Automobile-ийн "Aion S" загвар

PHEV гэж юу вэ?

PHEV /Plug-in hybrid electric vehicle/ буюу хайбрид цахилгаан автомашин нь дотоод шаталтат хөдөлгүүр болон цахилгаан гэсэн хосолсон хоёр хөдөлгүүртэй, цахилгаанаар давхар цэнэглэх боломжтойгоороо давуу талтай юм. БНХАУ-ын төрөөс дэмжлэг авах боломжтой суудлын PHEV нь нэг удаагийн цэнэглэлтээрээ 50 км-ээс дээш замыг туулах чадвартай байх шаардлагатай.

БНХАУ-д 2020 онд хамгийн их борлогдсон цахилгаан автомашин BYD-ийн "Qin pro" загвар

Төрийн бодлогоор хөгжүүлж буй цахилгаан автомашины салбарт БНХАУ-ын дөрвөн том автомашин үйлдвэрлэгч SAIC, FAW, CHANGAN, DONGFENG зэрэг компаниуд бүгд хөл тавиад байна.

Эдгээр компаниуд нь БНХАУ-ын "XII дахь таван жил"-ийн төлөвлөгөөний автомашины салбарын хөгжлийн зорилтод тусгагдсанаар "Их дөрөв" хэмээн нэрлэгдэх болжээ.

Компаниуд	Давуу тал
SAIC Motors	Wuling, Baojun зэрэг тэргүүлэгч цахилгаан автомашин үйлдвэрлэгчидтэй хамтарч ажилладаг
China FAW Group	Toyota, Wolksvagen, Audi, Mazda зэрэг гадаадын томоохон автомашины брэндүүдтэй хамтарч ажилладаг
Changan Automobile	Ford, Mazda, JMH зэрэг гадаадын томоохон автомашины брэндүүдтэй хамтарч ажилладаг
Dongfeng Motor Corporation	Өөрсдийн Dongfeng брэндийг БНХАУ-д түгээж чадсан

Эх сурвалж: Saic, Faw, Changan, Dongfeng

БНХАУ-д 2020 онд хамгийн их борлогдсон цахилгаан автомашин Great Wall Motors-ийн "Ora R1" загвар

ДҮГНЭЛТ

Дэлхий нийтээр ногоон хөгжлийг эрхэмлэж буй энэ цагт цахилгаан автомашины салбар эрчимтэй хөгжиж байна. БНХАУ нь энэ зах зээлд хэдийн байр сууриа эзэлсэн тул цаашдын хөгжилд нь үнэтэй хувь нэмэр оруулах болно гэж шинжээчид үзэж байна. Учир нь тус улсын "XII дахь таван жилийн төлөвлөгөө"-нд цахилгаан автомашины салбарыг хөгжүүлэх асуудлыг онцгойлон тусгаад байгаа юм.

Мөн засгийн газрын бодлого, дэмжлэгээс гадна цахилгааны автомашины цэнэглэгчийн хүртээмж зэрэг дэд бүтэц сайн хөгжсөн нь эерэг нөлөө авчрахаар байна. Түүнчлэн, урт хугацаанд компаниудын хүчтэй өрсөлдөөн нь салбарын хөгжлийг хурдасгах юм.

БНХАУ-д 2020 онд хамгийн их борлуулалттай 10 цахилгаан автомашины нэг Nio-ийн "ES6" загвар

ЦАХИЛГААН АВТОМАШИНЫ САЛБАРТ ЦАХИУР ХАГАЛЖ БУЙ КОМПАНИУД

Дэлхийн хэмжээнд цахилгаан автомашины үйлдвэрлэлд их бага хэмжээгээр оролцдог нийт 90 гаруй компани байдгаас 50 орчим нь хувьцаагаа биржээр арилжаалдаг.

Биржүүд дээрх цахилгаан автомашины үйлдвэрлэгчдийн тоо



Үүнээс 14 нь БНХАУ, 6 нь АНУ, 5 нь Германы хөрөнгийн биржид бүртгэлтэй байна.

Эдгээрээс бид Хятадын автомашины салбар, тэр дундаа дараагийн Теслаг хайж байгаа билээ.

Хятадын Шанхай, Шенжень, Хонг Конгийн биржид нийт 14 цахилгаан автомашин үйлдвэрлэгч компани хувьцаагаа арилжаалдаг. Эдгээрийг төрийн өмчит болон хувийн өмчит гэж ангилж болох юм.

Хятадын "XII дахь таван жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан, олон нийтийн дунд "Их дөрвөл" хэмээн нэрлэгдсэн төрийн өмчит дөрвөн цахилгаан автомашины компаниуд бол SAIC Motors, FAW, Donfeng, Changan юм.
Бид төрийн өмчит SAIC MOTORS, хувийн хэвшлээс BYD компаниудыг онцлон сонгож, дэлгэрэнгүй судалгааг бэлтгээд байна.

SAIC MOTORS

БНХАУ-ын тэргүүлэгч автомашин үйлдвэрлэгч

БНХАУ-ын төрийн өмчит 4 хувьцаат компанийн ерөнхий үзүүлэлтүүд /2020 он/

Компанийн нэр		Dongfeng Motor Group Co Ltd	FAW Jiefang Group Co Ltd	SAIC Motor Corp Ltd	Chongqing Changan Automobile Co Ltd
Үндсэн бирж		Хонг Конг	Шенжень	Шанхай-Хонг Конг	Шанхай-Хонг Конг
Валют		ХКД	ЮАНЬ	ЮАНЬ	ЮАНЬ
Зах зээлийн үнэлгээ - тэрбум		62.9	54.41	247.34	81.75
Байгуулагдсан он		5/18/2001	6/10/1997	4/16/1984	10/31/1996
Ажилчдын тоо		136,549	6,891	216,360	36,764
Ханшийн өөрчлөлт	1 жил	17.55	25.13	-9.91	63.34
	6 сар	32.49	-21.74	10.2	40.55
	3 сар	-5.56	-6.02	-17.37	-30.65
	1 өдөр	0.27	1.04	1.34	0.64
сая.юань /2019 оны байдлаар/	Нийт хөрөнгө	272,000.00	82,582.09	849,333.28	97,617.05
	Нийт өр төлбөр	138,032.00	54,074.90	548,493.66	53,682.98
	Борлуулалт	101,087.00	27,664.31	843,324.37	70,595.25
	Нийт ашиг	13,491.00	5,170.07	112,736.63	10,362.66
	Цэвэр ашиг	12,858.00	52.77	25,603.38	-2,646.72

Эх сурвалж: Bloomberg terminal

Г.Мөнх-Эрдэнэ
Дэд захирал,
munkh-erdene@golomtcapital.com

SAIC Motors нь 1950 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд 1984 онд албан ёсны компанийн эрхтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. Тус компани нь дэлхийд тэргүүлэгч 500 компаниудын 52, автомашин үйлдвэрлэгч компаниудын 7-д эрэмблэгддэг. 2019 онд зах зээлд эзлэх хувиараа 1-т жагсаж байсан юм.

Компани нь судалгаа шинжилгээ, үйлдвэрлэл, борлуулалт гэсэн гинжин сүлжээнд тулгуурласан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийт 216,360 ажилтантай.

SAIC Motors нь 2019 онд нийт 6,238 сая ширхэг автомашин борлуулсан нь БНХАУ-ын нийт зах зээлийн 22.7 хувийг дангаар хангаж буй үзүүлэлт юм. Мөн 350,000 машин экспортолсон нь өмнөх оныхоос 26.5 хувиар давсан өсөлт болсон.

Тус компани 2020 онд нийт 2,53 сая автомашин борлуулж, 390,000 автомашин экспортолсон нь өмнөх оныхоос 11 хувиар өссөн байна.

Харин 2019 онд 185,000 ширхэг цахилгаан автомашин борлуулсан нь жилийн дүнгээр 30.4 хувийн өсөлт бол 2020 онд 320,000 цахилгаан автомашин худалдсан нь өмнөх оноос 73 хувиар өссөн үзүүлэлт юм.

Энэ үзүүлэлт нь тус компани 2020 онд Теслагийн дараа орохуйц өндөр өсөлт үзүүлснийг илтгэж байна.

SAIC Motors компанийн үйлдвэрлэж буй хоёр ч загварын машин БНХАУ-ын хамгийн өндөр борлуулалттай ТОП-10 цахилгаан автомашинд зүй ёсоор багтаж байна.

Д/д	Компани	Брэнд	2020
1	Tesla Motors	Tesla Model 3	139,925
2	SAIC	Wuling HongGuang Mini EV	119,255
3	SAIC	Baojun E-Series	47,704
4	Great Wall	Ora R1 / Black Cat	46,774
5	GAC	Aion S	45,626
6	BYD	Qin Pro EV	41,621
7	Chery	Chery eQ	38,214
8	Li Auto	One EREV	33,186
9	BYD	Han EV	29,073
10	NIO	ES6	27,961
Total			**569,339**

SAIC MOTORS КОМПАНИАС ХИЙСЭН ОНЦЛОХ МЭДЭГДЛҮҮД:

- **2020 оны 10 сар**
  SAIC Motors нь 2001 оноос хойш устөрөгчийн автомашин үйлдвэрлэлийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэлтэд нийт 3 тэрбум юань зарцуулж, 511 патентийг өөрийн нэр дээр авсан байна. 2025 он гэхэд хамгийн багадаа 10 шинэ загварын устөрөгчийн автомашин үйлдвэрлэж, 10,000 ширхгийг худалдахаа мэдэгдсэн байна.
  БНХАУ-ын засгийн газрын зүгээс энэ төрлийн автомашиныг цэнэглэх станцуудыг 2030 он гэхэд 1000 ширхгийг барьж 1,000,000 автомашиныг цэнэглэх хүчин чадалтай болно гэж төлөвлөжээ.

- **2020 оны 11 сар**
  SAIC Motors компанийн ерөнхийлөгчийн мэдэгдэж буйгаар, 2025 он гэхэд 100 шинэ загварын автомашиныг бүтээх бөгөөд үүнээс 20 нь цахилгаан автомашин, 10 нь устөрөгчийн автомашин байх юм. Компани 2025 он гэхэд хилийн чинадад жилд 1,5 сая ширхэг автомашин худалддаг болохоор зорьж байна.

- **2020 оны 12 сар**
  Алибаба болон дэлхийн цахилгаан автомашины батарей үйлдвэрлэгч хамгийн том компани болох Contemporary Amperex Technology нь SAIC Motors-ын охин компанид хөрөнгө оруулалт хийж, шинэ төрлийн батарейн үйлдвэрлэл эхлүүлэх болсноо зарлав.

- **2021 оны 1 сар**
  Алибаба SAIC Motors-ийн хөгжүүлж буй хоёр төрлийн загвар байгаа бөгөөд 4 дүгээр сард анхны захиалга авч эхлэхээр төлөвлөжээ. Уг машинууд нь нэг удаагийн цэнэглэлтээр 1000 км зам туулах хүчин чадалтай байх юм.

- **2021 оны 2 сар**
  Оны эхний сард хилийн чинадад худалдсан автомашины тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63.3 хувиар өсчээ.

- **2021 оны 2 сар**
  Оны эхний сард худалдсан цахилгаан автомашины тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 446.6 хувиар өсч 58,000-д хүрэв.

Хөрөнгө оруулагчид



- Shanghai Automotive Industry Corp - 71.24%: 1955 онд БНХАУ-д байгуулагдсан автомашин үйлдвэрлэгч
- Yuejin Motors Group Co - 3.54%: 1947 онд БНХАУ-д байгуулагдсан автомашин үйлдвэрлэгч
- Hong Kong Securities Clearing Co Ltd - 3.27%: 2000 онд Хонг Конгод байгуулагдсан бирж
- China Securities Finance Corp Ltd - 2.99%: 2011 онд БНХАУ-д байгуулагдсан санхүүгийн байгууллага
- China Investment Corp - 0.86%: 2007 онд байгуулагдсан БНХАУ-ын төрийн өмчийн хөрөнгө оруулалтын сан ба 950 тэрбум ам.долларын хөрөнгө удирддаг.
- Guangdong Hengjian Investment Holding Co Ltd - 0.68%: БНХАУ-ын Guangdong мужийн захиргааны эзэмшлийн санхүүгийн байгууллага ба 37 тэрбум ам.долларын хөрөнгөтэй.
- People's Republic of China Ministry of Finance - 0.74%: БНХАУ-ын Сангийн яам эзэмшдэг.

Санхүүгийн эрүүл мэнд: Сайн

2020 онд коронавирусын цар тахлын улмаас компанийн орлого буурсан ч эдийн засаг сэргэснээр нааштай үр дүн гарч цаашид ч өсөлтөө хадгалах боломжтой байна.
Ковид 19-ийн эрсдэлтэй нөхцөлд эрэлтийн харьцаа хэвийн, санхүүгийн хөшүүрэг нэмэгдээгүй нь мөнгөн хөрөнгийн хүрэлцээ хангалттай, богино ба урт хугацааны өр төлбөр, өглөгийг бүрэн төлөх чадвартайг илтгэж байгаа нь сайн үзүүлэлт юм.

Баланс



Орлогын тайлан



сая ам.доллараар	Бодит	Бодит	Бодит	Бодит	Бодит	Бодит	Сүүлийн 12 сар	Таамаглал	Таамаглал
Сүүлийн 12 сар	12/31/2014	12/31/2015	12/31/2016	12/31/2017	12/31/2018	12/31/2019	9/30/2020	12/31/2020	12/31/2021
Эргэлтийн хөрөнгө	38,187.10	41,812.10	47,701.70	59,930.30	65,912.00	73,406.30	75,929.30		
Эргэлтийн бус хөрөнгө	28,647.80	37,256.30	37,418.70	51,267.90	47,887.50	48,564.70	48,621.50		
Нийт хөрөнгө	66,834.90	79,068.40	85,120.40	111,198.20	113,799.50	121,971.10	124,550.80		
Нийт өр төлбөр	37,031.90	46,557.00	51,217.90	69,378.80	72,406.70	78,768.10	79,846.20		
Нийт эздийн өмч	29,803.00	32,511.30	33,902.50	41,819.30	41,392.80	43,203.00	44,704.60		
Борлуулалтын орлого	101,645.70	105,807.30	113,906.80	128,982.00	136,494.80	122,104.40	108,020.50	117,501.10	130,259.00
Нийт ашиг	12,351.40	12,194.40	15,663.30	18,581.60	19,413.10	16,323.10	12,978.20	14,855.70	17,587.60
Цэвэр ашиг	4,540.40	4,741.50	4,819.70	5,097.80	5,447.90	3,707.10	3,063.50	3,433.80	4,438.30
Чөлөөт мөнгөн урсгал	5,127.90	6,063.30	3,357.00	3,934.10	1,303.30	6,699.60	8,955.70	-562.8	4,065.90
Эргэлтийн харьцаа	1.19	1.05	1.11	1	1.09	1.1	1.19		
Өр ба хөрөнгийн харьцаа	16.25	18.44	19.99	23.34	27.79	29.46	30.67		
Хөрөнгийн эргэц	1.59	1.43	1.37	1.32	1.2	1.03	0.92		
Нийт ахиуц ашиг	12.15	11.53	13.75	14.41	14.22	13.37	12.01		
Цэвэр ахиуц ашиг	4.47	4.48	4.23	3.95	3.99	3.04	2.84	2.88	3.36
Санхүүгийн хөшүүрэг	2.67	2.79	3.01	3.15	3.28	3.37	3.35		
Нийт хөрөнгийн өгөөж	7.1	6.42	5.8	5.24	4.78	3.14	2.6	3.25	3.87
Нийт эздийн өмчийн өгөөж	18.94	17.91	17.43	16.49	15.67	10.58	8.6	8.47	10.21
Ногдол ашгийн дундаж өгөөж	7.65	5.93	6.44	5.76	5.9	5.03			
P/S	0.38	0.35	0.34	0.43	0.35	0.33	0.33	0.32	0.29
P/B	1.5	1.34	1.35	1.66	1.33	1.12	0.96	0.94	0.88
P/E	8.46	7.85	8.08	10.83	8.65	10.89	11.47	11.2	8.66
Ажилчдын тоо	151,820.00	163,817.00	171,395.00	180,749.00	217,511.00	216,360.00			
Нэг ажилтанд ногдох орлого	669,514.24	645,887.33	664,586.41	713,597.40	627,530.77	564,357.43			

Эх сурвалж: Bloomberg

Хувьцааны үнэлгээ: Багаар үнэлэгдсэн /undervalued/

Үнэлгээний харьцаа



Эх сурвалж: Bloomberg terminal, 2021 оны 03-р сарын 04-ний байдлаар

P/S харьцааг харвал түүхэн үзүүлэлтийнхээ доод хязгаарт байгаа нь багаар үнэлэгдсэн, P/E харьцааг харвал түүхэн үзүүлэлтийнхээ дээд хязгаарт байгаа нь өндрөөр үнэлэгдэж буйг илтгэх үзүүлэлт юм. Үүнийг өрсөлдөгч компаниуд буюу ижил төрлийн төрийн өмчийн үйлдвэрлэгчидтэй харьцуулахад P/E харьцаа 6.4-өөр бага, P/S харьцаа 0.38-аар бага байгаа нь "багаар үнэлэгдсэн" гэж дүгнэхэд хүргэж байна.

Техник шинжилгээ:

Унах хандлага бүрэн дуусахыг хүлээж, өсөлтийн дохионууд баталгаажихыг хүлээх шаардлагатай.



Эх сурвалж: Bloomberg terminal, Долоо хоногийн лаан графикт үндэслэв

Техник шинжилгээнээс харвал урт хугацааны ханшийн өсөх хандлага 2006 оноос эхэлсэн бөгөөд одоогоор хандлагын доод хэсгийн 25 хувь орчимд хэлбэлзэж байна.

Ханш ба MACD-ийн хооронд диверженс үүссэн байгаа нь 2019 оноос хойшхи ханшийн уналт дуусч, эргэх дохиог хэдийн өгч эхэлжээ. Уг дохионы дагуу ханш 2020 оны 2 дугаар хагасаас өсч эхэлсэн ч эргээд энэхүү өсөлтийнхөө 61.8 хувийг алдаад байна.

Мөн хандлагын хүчийг илэрхийлэгч DMI индикатор нь ханш худалдан авах ба худалдах талын хүч тэнцэж буйг илэрхийлж байна. Харин моментум болох RSI нь тодорхой бус байна. Нэгтгэн харвал ханшийн уналт дөхөж буй бөгөөд эргээд богино хугацааны уналтыг доороос дээш нэвтлэн гарсны дараа худалдан авах нь илүү эрсдэл багатай юм.

ДҮГНЭЛТ:

Суурь шинжилгээнээс харахад хувьцааны үнэлгээ "багаар үнэлэгдсэн" гэж үзэж болохоор байгаа ч техник шинжилгээний үр дүнд ханшийн өсөлт эхэлж буйг батлахуйц дохионууд илрээгүй байна. Харин богино хугацааны ханшийн уналт дуусч, эргэлт дөхөж буй шинж тэмдгүүд байна.

BYD - ТЭРГҮҮЛЭГЧ ТЕХНОЛОГИ

Биржид хувьцаагаа арилжаалж буй БНХАУ-ын хувийн хэвшлийн томоохон цахилгаан автомашин үйлдвэрлэгчдийн ерөнхий үзүүлэлтүүд /2020 он/

Компаний нэр	Үндсэн бирж	Валют	Зах зээлийн үнэлгээ - тэрбум	Байгуулагдсан он	Ажилчдын тоо	Ханшийн өөрчлөлт				сая.юан /2019 оны байдлаар/				
						1 жил	6 сар	3 сар	1 өдөр	Нийт хөрөнгө	Нийт өр төлбөр	Борлуулалт	Нийт ашиг	Цэвэр ашиг
Geely Automobile Holdings Ltd	Хонг Конг	ХКД	256.76		38,000.00	85.46	58.29	26.94	0.77	107,927.58	53,003.11	97,401.25	16,916.63	8,189.64
BYD Co Ltd	Хонг Конг	ХКД	681.03	2/10/1995	249,900.00	332.26	152.24	24	-0.09	195,641.59	133,040.17	121,778.12	18,075.99	1,614.45
Great Wall Motor Co Ltd	Хонг Конг	ХКД	303.66	6/5/2001	59,756.00	301.4	160.77	60.39	3.37	113,096.41	58,697.18	96,210.69	16,187.62	4,496.87
Chongqing Sokon Industry Group Co Ltd	Шанхай-Хонг Конг	ЮАНЬ	26	1986	14,317.00	92.98	130.35	-1.69	10.01	29,935.10	22,081.47	18,132.01	3,137.58	66.72
Brilliance China Automotive Holdings Ltd	Хонг Конг	ХКД	35.57	6/9/1992	5,390.00	6.03	3.22	7.14	2.17	49,470.00	14,994.55	3,861.95	74.38	6,762.71
Zotye Automobile Co Ltd	Шенжень-Хонг Конг	ЮАНЬ	6.37	8/31/1998	8,098.00	19.39	122.7	110.74	5.02	20,436.58	14,048.87	2,985.85	-174.93	-11,190.22
Haima Automobile Co Ltd	Шенжень-Хонг Конг	ЮАНЬ	5.02	1/26/1993	3,655.00	25.51	8.54	-5.57	0.33	10,728.94	5,007.07	4,832.21	364.08	85.2
Guangzhou Automobile Group Co Ltd	Хонг Конг	ХКД	115.97	6/6/1997	91,835.00	-22.04	9.09	-9.63	1.39	137,463.55	54,955.31	59,704.32	2,522.96	6,616.27
Wuling Motors Holdings Ltd	Хонг Конг	ХКД	6.33	8/24/1992	10,309.00	638.46	481.82	110.99	-1.03	15,692.56	13,387.23	14,237.31	1,172.16	-124.03
BAIC Motor Corp Ltd	Хонг Конг	ХКД	22.76	9/20/2010	21,712.00	-29.35	-21.76	1.43	0.71	196,393.07	124,018.29	174,632.72	37,487.02	4,082.70
Zhengzhou Yutong Bus Co Ltd	Шанхай-Хонг Конг	ЮАНЬ	35.09	1/8/1993	18,082.00	2.19	4.14	-12.38	0.89	36,706.63	19,011.34	30,479.44	7,421.48	1,940.21
Anhui Jianghuai Automobile Group Corp Ltd	Шанхай-Хонг Конг	ЮАНЬ	16.77	9/30/1999	24,487.00	44.54	7.39	-16.81	1.61	43,854.52	30,150.15	47,362.15	5,042.48	106.01
Jiangling Motors Corp Ltd	Шенжень-Хонг Конг	ЮАНЬ	13.94	11/28/1993	14,788.00	69.34	52.72	15.27	1.72	24,298.53	13,801.96	29,173.64	4,642.78	147.81
Lifan Industry Group Co Ltd	Шанхай-Хонг Конг	ЮАНЬ	26.71	12/1/1997	7,185.00	99.32	36.26	9.06	-	19,406.96	16,573.42	7,449.77	-224.93	-4,682.08

Г.Мөнх-Эрдэнэ
Дэд захирал,
munkh-erdene@golomtcapital.com

BYD компани нь 1995 онд батарейн технологиор тэргүүлэгч компани болох зорилттойгоор байгуулагдсан. Эдүгээ 100 хувь цахилгаан автомашин үйлдвэрлэгч дэлхийд тэргүүлэгч компани болж хөгжжээ. БНХАУ-ын Шенжень хотод төвтэй тус компани нь дэлхий даяар 30 гаруй аж үйлдвэрлэлийн парктай, 229,000 гаруй ажилтантай болж үйл ажиллагаа нь өргөжин тэлээд байна.

Компанийн нийт орлогын 50 хувь нь батарей, 50 хувь нь цахилгаан автомашины борлуулалтаас бүрддэг. Гар утаснаас эхлээд автомашины бүх төрлийн батарей үйлдвэрлэдэг тус компанийн гол давуу тал нь дахин цэнэглэгддэг батарей үйлдвэрлэдэгт оршдог юм.

Алдарт хөрөнгө оруулагч Уоррен Буфет 2008 онд тус компанийн хувьцааг 8 ам.доллараар худалдан авч байсан бол одоо компанийн 25 хувийг эзэмшдэг.

2014 онд BYD компани нь Бразилид анхны төмөр-фосфатын батарейн үйлдвэрийг байгуулах гэрээ байгуулсан бол 2015 онд Лондонгийн автобуснуудыг тус компанийн бүтээгдэхүүнээр шинэчлэх ажлыг эхлүүлсэн байдаг. Харин 2017 онд АНУ-д хамгийн том цахилгаан автомашины үйлдвэрийг ашиглалтад оруулсан бөгөөд энэ нь АНУ дахь анхны Хятадын эзэмшил бүхий компани болсон юм.

BYD КОМПАНИАС ХИЙСЭН ОНЦЛОХ МЭДЭГДЛҮҮД

2020 оны 09 сарын 1
BYD компани нь лити төмрийн фосфатын батарей үйлдвэрлэх анхны үйлдвэр буюу нийтдээ гурав дахь үйлдвэрээ Бразилид нээж үйл ажиллагааг нь эхлүүллээ.

2.7 сая ам.долларын хөрөнгө оруулалттай уг үйлдвэр нь 5,000м2 талбайг хамрах юм. Жилд нийт 48 төрлийн 18 мянган батарей үйлдвэрлэх хүчин чадалтай. Тус компани Бразилид 2015 болон 2017 онд цахилгаан автомашины хоёр үйлдвэрийг ашиглалтад оруулсан юм. Ингэснээр тус улсын шатахууны зардлыг 75 хувиар бууруулахад хувь нэмрээ оруулж байна.

2020 оны 9 сарын 14
BYD-ийн цахилгаан автобусыг Канадын хамгийн том, Хойд Америкийн гурав дахь том транзит тээврийн компани худалдан авч үйлчилгээндээ нэвтрүүлэв.

2020 оны 10 сарын 21
BYD Auto Industry Co.,Ltd(BYD) болон Hino Motors, Ltd нь хамтран цахилгаан автомашины батеррейн үйлдвэр барих хамтарсан компанийг үүсгэн байгуулав. Шинэ компани нь 2021 онд БНХАУ-д байгуулагдах ба хөрөнгө оруулалтаа 50:50 хувиар гаргах юм.

2020 оны 11 сарын 9
BYD компаниас БНСУ-д байрлалтай Zyle Daewoo автомашины үйлдвэрийг худалдан авах судалгааг хийжээ. Тус компани нь жилд 7,000 автобус үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд бүс нутгийн импортлогчдоор дамжуулан борлуулдаг юм.

2020 оны 12 сарын 17
Японы Нагасаки хотын нийтийн тээвэрт BYD компанийн үйлдвэрлэсэн цахилгаан автобуснууд үйлчилж эхлэв.

2020 оны 12 сарын 18
Колумбын нийтийн тээвэрт 470 ширхэг цахилгаан автобусыг нийлүүлснээр Америк тив дэх хамгийн том автобус бааз байгуулагдлаа.

Хөрөнгө оруулагчид



- Berkshire Hathaway Inc – 24.59%: 1962 оноос алдарт хөрөнгө оруулагч Варрен Буффет хувьцааг нь худалдаж авч даатгалын байгууллага болгосон бөгөөд хувьцааны хөрөнгө оруулалтаар мэргэшсэн дэлхийн зургаа дахь баян эрхэм юм.

- Himalaya Capital Investors LP–8.24%: 1997 онд БНХАУ-д байгуулагдсан ба Berkshire Hathaway-ийг даган хөрөнгө оруулалт хийдэг хөрөнгө оруулалтын менежментийн компани юм.

- Citigroup Inc–4.41%: 1998 онд АНУ-ын Citicorp болон Travelers Group нар нэгдэж байгуулсан. 1.9 орчим их наяд ам.долларын хөрөнгөтэй Өмнөд Америк, Ази, Европ тивүүдэд салбартай томоохон санхүүгийн байгууллага юм.

- Vanguard Group–2.85%: 1975 онд АНУ-д байгуулагдсан 6.2 их наяд ам.долларын хөрөнгө удирддаг.

- JPMorgan Chase & Co–2.83%: 1871 онд АНУ-д байгуулагдсан 3 их наяд ам.долларын хөрөнгө удирддаг.

- BlackRock Inc–2.49%: 1988 онд АНУ-д байгуулагдсан 7.5 их наяд ам.долларын хөрөнгөтэй хөрөнгө оруулалтын менежментийн компани юм.

Санхүүгийн эрүүл мэнд: Сайн

Санхүүгийн хөшүүрэг харьцангуй өндөр ч борлуулалтын орлогын өсөлтийг нь харахад эрсдэлийг даахуйц, эргэлтийн харьцаа нь коронавирусын дэгдэлтийн үед алдагдаагүй нь компанийн бизнес тогтвортой байгааг илтгэж байна. Харин хөрөнгийн эргэц харьцангуй бага байгаа бол ашигт ажиллагаа нь хэвийн байна. Эндээс дүгнэхэд борлуулалтын орлогыг өсгөх шаардлага үүсч байна.

Баланс



Орлогын тайлан



сая ам.долларраар	Бодит	Бодит	Бодит	Бодит	Бодит	Бодит	Сүүлийн 12 сар	Таамаглал	Таамаглал
Сүүлийн 12 сар	12/31/2014	12/31/2015	12/31/2016	12/31/2017	12/31/2018	12/31/2019	9/30/2020	12/31/2020	12/31/2021
Эргэлтийн хөрөнгө	6,578.30	8,403.70	11,274.30	15,781.30	16,771.00	15,361.30	15,870.20		
Эргэлтийн бус хөрөнгө	8,566.30	9,397.60	9,630.20	11,590.40	11,515.80	12,734.40	13,109.20		
Нийт хөрөнгө	15,144.60	17,801.30	20,904.50	27,371.70	28,286.80	28,095.70	28,979.40		
Нийт өр төлбөр	10,489.80	12,247.60	12,920.10	18,157.00	19,463.10	19,105.60	18,986.80		
Нийт эздийн өмч	4,654.80	5,553.60	7,984.40	9,214.70	8,823.70	8,990.10	9,992.60		
Борлуулалтын орлого	8,986.50	12,351.50	15,581.30	15,690.90	18,426.00	17,632.20	19,835.40	22,678.80	29,101.60
Нийт ашиг	1,237.40	1,887.30	3,172.80	2,983.60	2,733.40	2,617.20	3,934.40	3,766.00	4,640.80
Цэвэр ашиг	70.4	449.3	760.8	602.4	420.6	233.8	493.1	704.4	909
Чөлөөт мөнгөн урсгал	-638.2	-365.5	-2,563.30	-1,566.80	-330.5	113.6	3,131.20	892.7	524.9
Эргэлтийн харьцаа	0.77	0.82	1	0.98	0.99	0.99	1.08		
Өр ба хөрөнгийн харьцаа	32.07	32.6	39.99	40.78	33.25	39.23	35.4		
Хөрөнгийн эргэц	0.64	0.74	0.79	0.66	0.65	0.62	0.7		
Нийт ахиуц ашиг	13.77	15.28	20.36	19.01	14.83	14.84	19.84		
Цэвэр ахиуц ашиг	0.78	3.64	4.88	3.84	2.28	1.33	2.49	3.13	3.1
Санхүүгийн хөшүүрэг	3.65	3.85	3.4	3.28	3.64	3.76	3.51		
Нийт хөрөнгийн өгөөж	0.5	2.7	3.88	2.52	1.49	0.83	1.75	2.37	2.77
Нийт эздийн өмчийн өгөөж	1.84	10.22	12.72	7.76	4.96	2.62	5.81	7.79	8.93
Ногдол ашгийн дундаж өгөөж	0.14	0	0.01	1.22	0.3	0.52			
P/S	1.06	1.14	0.91	1.46	0.98	0.78	3.2	3.59	2.8
P/B	2.37	3.04	2.1	3.03	2.33	1.81	7.81	7.23	6
P/E	134.98	31.77	19.45	40.51	47.17	69.46	145.24	97.82	75.56
Ажилчдын тоо	16.71	15.53	12.29	16.14	11.83	12.41		29.27	26.11
Нэг ажилтанд ногдох орлого	190,000.00	200,000.00	193,842.00	200,949.00	221,000.00	229,000.00			

Хувьцааны үнэлгээ: Өндрөөр үнэлэгдсэн /overvalued/

Үнэлгээний харьцаа



Эх сурвалж: Bloomberg terminal, 2021 оны 03-р сарын 04-ны байдлаар

P/S харьцааг харвал түүхэн үзүүлэлтээсээ хэт их өссөн, P/E харьцаа нь ч мөн адил хэт өндөр байна. Өрсөлдөгч компаниуд болох ижил төрлийн хувийн өмчит үйлдвэрлэгчидтэй харьцуулахад үнэлгээний харьцаа үзүүлэлтүүд нь өндөр байгаа юм.

Техник шинжилгээ

Эх сурвалж: Bloomberg terminal, Долоо хоногийн лаан графикт үндэслэв

Ханшийн өсөх хандлага эргэж буйг MACD-ийн үзүүлэлтүүд оргилоос буурч, DMI-ийн үзүүлэлтүүд харилцан бие биедээ дохож байгаагаас харж болно. Хөдөлгөөнт дунджаас харахад ханш бага зэргийн зогсолт хийгээд дахин буурах магадлалтай байна. Эндээс дүгнэхэд ханшийн уналт үргэлжилж байгаа тул эргэлт болж буйг батлах дохионуудыг хүлээх шаардлагатай.

ДҮГНЭЛТ:

BYD компанийн өнгөрсөн хугацааны өсөлтийн түүх, бүтээгдэхүүнийн чанар, дэлхийд танигдсан байдал нь ирээдүйд өсөлт үзүүлэх боломжтойг илтгэж байна. Санхүүгийн хувьд харьцангуй тогтворжсон, эрсдэлтэй үеэ давжээ.

Гагцхүү одоогийн ханшинд ирээдүйн урт хугацааны өсөлтийг шингээсэн байгаа тул өндрөөр үнэлэгдэхэд хүргэж байна. Тиймээс ханшийн хөдөлгөөнийг анхааралтай ажиглаж, суурь ба техник шинжилгээг хослуулснаар оновчтой цаг мөчид хөрөнгө оруулалт хийх нь чухал байна.

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙГ ЗЭС, НҮҮРСНИЙ ЭКСПОРТ БҮРДҮҮЛНЭ

Г.Батзориг
Голомт банк,
Ахлах эдийн засагч
batzorig_g@golomtbank.com

Цар тахлын шокоос үүдэлтэй эдийн засгийн уналт бүтэн жилийн турш үргэлжлэв. Манай улсад өмнө нь тохиож байсан хямралууд эрэлт хэт халснаас үүсэж байсан бол энэ удаад нийлүүлэлтийн дутагдал үүссэн нь шийдвэр гаргагчдад томоохон сорилт болж байна. Тиймээс ямар ч сангийн болон мөнгөний бодлого үр дүнгээ өгсөнгүй гэж дүгнэж болох юм.

Монгол Улс 2020 оны төгсгөлд дотооддоо цар тахлыг алдсанаар 8 дүгээр сараас аажмаар сэргэж байсан эдийн засаг эргэн унахад хүрэв. Энэ хүнд үед алтны экспорт жилийн 280 хувь өссөн нь эдийн засгийг тогтворжуулахад томоохон нөлөө үзүүлсэн юм. Харин 2021 оны хувьд зэс, нүүрсний экспортын өсөлтөд өндөр найдлага тавьж байна.

Нүүрсний үнэ
ам.доллар



Эх сурвалж: Bloomberg

Зэсийн үнэ
мянган ам.доллар



Эх сурвалж: Bloomberg

Учир нь гадаад зах зээлд БНХАУ-ын эдийн засаг хурдацтай сэргэж, түүхий эдийн эрэлт нэмэгдэж байна.

Мөн тус улсад зэс нийлүүлдэг голлох улс болох Чилид коронавирусын цар тахал дэгдсэнээс үүдэн зэсийн үнэ түүхэн дээд ханшиндаа хүрээд байгаа юм.

Мөн БНХАУ-аас Австралийн нүүрсэнд тавьсан импортын хориг нь манай улсад эерэг нөлөө авчрахуйц байна.

Тиймээс 2021 онд зэс, нүүрсний үнэ харьцангуй тогтвортой байх хүлээлттэй байгаа юм. Өөрөөр хэлбэл, 2021 онд манай улсын эдийн засагт уул уурхайн салбар, түүнийг дагасан худалдаа, тээврийн салбар эерэг нөлөө үзүүлэхээр байна.

1991 он
Монголд хөрөнгийн зах зээлийн үндэс суурь тавигдав
Өмч хувьчлалыг зохион байгуулж, хувийн өмч, секторыг бий болгох зорилгоор, 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Монголын Хөрөнгийн биржийг байгуулав.

1994.09.26
Анхны Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдав
Тус хууль батлагдсанаар Үнэт Цаасны Хороо байгуулагдсан юм. Мөн МХБ-ийн түр дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд зөвхөн үнэт цаас арилжих, түүнтэй холбоотой ажил үйлчилгээ эрхлэх зорилго бүхий төрийн өмчийн, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн статустай болсон юм.

1996.10.25
Засгийн газрын бондын анхны арилжаа явагдав
Засгийн газар 1996 онд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор анх бонд гаргасан. Харин 2011 онд Засгийн газрын бондын арилжаа 14 удаа явагдаж, "4000 төрийн албан хаагчдыг орон сууцны урт хугацаат зээлд хамруулах" хөтөлбөрийн санхүүжилтэд 65 тэрбум төгрөгийн бонд, ноос ноолуурын болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр"-ийн санхүүжилтэд 171.7 тэрбум төгрөгийн бонд арилжиж, нийт 236.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2.4 сая ширхэг бондыг арилжаалж байжээ.

Монголын хөрөнгийн зах зээл 30 1991-2021 жилийн ой

1992.02.07
Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдав
1992-1995 оороно нийт 475 төрийн өмчит компаниудыг хувьчилж нээлттэй компанид шилжүүлсэн. Ингэхдээ нийт 8.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 96.1 сая ширхэг хувьцааг МХБ-ээр дамжуулан иргэдэд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр эзэмшүүлснээр нийт хүн амын 52 орчим хувь буюу 1.2 сая хүн хувьцаа эзэмшигч болжээ.

1995 он
Иргэд хөрөнгийн зах зээлийн хоёрдогч арилжаанд оролцож эхлэв
1995 оны 8 дугаар сарын 8-ны өдөр МХБ-д хоёрдогч зах зээлийн арилжааг нээснээр, хөрөнгө оруулагчид хоорондоо арилжаа хийх боломжтой болов.

2001.06.08
Компанийн бондын арилжаа явагдаж эхлэв
Барилга корпораци ХХК нь "Шинэ зуун-210" нэртэй 210,000 ширхэг компанийн бондыг МХБ-д бүртгүүлж арилжаалсан нь компанийн бонд гаргасан анхны компани болов.

2005 он
Санхүүгийн Зохицуулах Хороог байгуулав
Санхүүгийн Зохицуулах Хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг баталж, Хоршооны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулж Санхүүгийн Зохицуулах Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгохоор хуульчилж банкнаас бусад санхүүгийн салбарыг хамарсан зохицуулагч байгууллага Үнэт Цаасны Хорооны суурин дээр байгуулагдав.

2015 он
Хамгийн олон хувьцаа эзэмгигчтэй хувьчлал-Монгол Шуудан ТӨХК
Тус компанийн 34 хувийг хувьчилж, 6.2 тэрбум төгрөг татсан нь монголын хөрөнгийн зах зээлийн түүхэн дэх хамгийн их иргэд хувьцааг нь авсан хувьчлал болов.

2008 он
СЗХ-ны зүгээс "Блүүмбэрг" агентлагтай үнэт цаасны зах зээлийн мэдээллийг дамжуулах гэрээ байгуулав.

2011 он
Анхны банкны хөрөнгө оруулалтай брокерийн компани болох Голомт Капитал ҮКЦ ХХК байгуулагдав.

2005.05.25
Анхны IPO гарав
Монгол Шилтгээн ХХК нь 800 сая төгрөгийн үнийн дүн бүхий 1 сая ширхэг хувьцааг МХБ-д бүртгүүлж, олон нийтэд нээлттэйгээр санал болгон арилжаалснаар IPO хийсэн анхны компани болов.

2007он
Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн жил болгон зарлав
Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Хөгжлийн байгууллагаас баталсан "Компанийн засаглалын зарчмууд"-д үндэслэн үндэсний "Компанийн засаглалын кодекс"-ийг батлав.

2010 он
Төвлөрсөн хадгаламж дахь үнэт цаасны бүртгэлийг ISO6166 олон улсын стандартын дагуу бүртгэхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангаж, олон улсын стандартыг хэрэгжүүлэгч байгууллага болох ANNA-д хамтрагч байгууллагаар элсэн орлоо.

2012 он
Голомт Капитал ҮЦК ХХК нь Монголын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох боломжтой анхны онлайн арилжааны системийг нэвтрүүлэв. Энэ нь иргэд заавал брокерын компани дээр очиж захиалга өгдгийг өөрчилж, хүссэн үедээ интернэтэд холбогдсон төхөөрөмж ашиглан хдотоодын хувьцаа, бонд худалдан авах, зарах боломжийг бий болгосон юм.

2013 он
Монголын үнэт цаасны салбарын хууль, эрх зүйн орчинд шинэчлэл хийгдэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг шинэчлэн, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг шинээр баталж, олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх суурийг амжилттай тавилаа.

2014 он
СЗХ-оос Голомт банкинд Кастодиан банкны тусгай зөвшөөрлийг олголоо. Ингэснээр Монгол Улсад анх удаа үнэт цаасыг найдвартай хадгалах, төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээ нэвтэрсэн юм. Ингэснээр Хөрөнгө оруулалтын сангуудын хөрөнгийг найдвартай хадгалах, иргэдийн үнэт цаасыг хадгалж, төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх, цаашилбал Хувийн тэтгэврийн санг байгуулахад түүний хөрөнгийг хадгалах, бүртгэл тооцоог хийх бие даасан институци бий болсон юм.

2017он
"Сүү" ХК-ийн хувьцаагаар баталгаажсан 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нэг жилийн хугацаатай, жилийн 17.5 хувийн хүүтэй өрийн хэрэгсэл болох "Сүү Бонд" нь 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Монголын Хөрөнгийн Биржээр олон нийтэд нээлттэйгээр худалдагдаж, анхдагч зах зээлд нийт 6 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлд нийт 4.7 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан нь Монголын хөрөнгийн зах зээлд арилжигдсан хамгийн өндөр үнийн дүнтэй өрийн хэрэгсэл болсон юм. Тус бондын андеррайтераар Голомт Капитал ҮЦК ХХК ажиллав.

2018
Даатгалын зах зээлийн анхны IPO амжилттай хэрэгжиж, Мандал Даатгал ХК 7.5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүллээ. Тус IPO-ийн андеррайтераар Голомт Капитал ҮЦК ХХК ажилласан юм.

2013 он
СЗХ, Төрийн өмчийн хороотой санамж бичиг байгуулав. Санамж бичгийн үндсэн зорилго нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хувьцаат компаниудын үйл ажиллагаанд компанийн сайн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэн, менежментийг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршиж байв.

2015 он
Анхны даатгагдсан бонд Эрчим бондыг нээлттэй зах зээлд санал болгож амжилттай арилжаалаа. Бондын андеррайтераар Голомт банк, Голомт Капитал ҮЦК ХХК ажилласан бөгөөд 2016 онд бондын эргэн төлөлт амжилттай хийгдсэн билээ.

2018.03.13
Хамгийн их захиалга авсан IPO хийгдлээ.
Банк бус санхүүгийн зах зээлийн төлөөлөл ЛэндМн ББСБ ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн худалдан авах захиалга нь нийлүүлэлтээсээ 16.5 дахин их буюу нийт 41 тэрбум төгрөгт хүрснээр, Монголын хөрөнгийн зах зээлд үнэт цаас гаргасан компаниуд дунд хамгийн их захиалга авсан компани болов.

2018
Монголын Хөрөнгийн бирж дээрх анхны давхар бүртгэл болох Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн компанийн 2.6 тэрбум төгрөгийн нэмж хувьцаа гаргалтын хамтрагч андеррайтераар Голомт Капитал ҮЦК ХХК ажиллав.

2019
Санхүүгийн Зохицуулах Хороо нь Эрдэнэс Тавантолгой компанийг хаалттай хувьцаат компаниар бүртгэж, хувьцааг нь хадгаламжид бүртгэн авахыг зөвшөөрөв.

2020
Монголын хөрөнгийн зах зээлд төлбөр тооцооны эсрэг нийцүүлэлт буюу DVP T+2 горим амжилттай нэвтэрлээ. Тус горимд нэвтэрснээр хувьцааны хөрвөх чадвар сайжрах, ҮЦК-иуд харилцагчдадаа өндөр өгөөж өгөх боломжийг бий болгосон юм.

2020
Анхны хайбрид бонд болох Мастер бондыг хаалттай хүрээнд санал болгож, амжилттай ажрилжаллаа. Тус бондын андеррайтераар Голомт Капитал ҮЦК ХХК ажиллав.

2020
Анхны банкны баталгаат бонд болох Нөмөр бондыг хаалттай хүрээнд санал болгож, амжилттай ажрилжаллаа. Тус бондын андеррайтераар Голомт Капитал ҮЦК ХХК ажиллав.

2019
Монголын Хөдөө аж ахуйн салбарын анхны IPO амжилттай хэрэгжиж, Түмэн Шувуут ХК нь зах зээлээс 10 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлснээр олон нийтийн компани болов. Тус IPO-ийн андеррайтераар Голомт Капитал ҮЦК ХХК ажилласан юм.

2019
Монголын эрүүл мэндийн шингэн хүнсний зах зээлд тэргүүлэгч Монос Хүнс ХК-ийн IPO хүрээнд 8.7 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүллээ. Тус IPO андеррайтераар Голомт Капитал ҮЦК ХХК ажилласан юм.

2020
Монголын хамгийн олон буюу 2,5 сая хувьцаа эзэмшигчтэй Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТУЗ-өөс нэгж хувьцаандаа 90 төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэв. Ингэснээр 2020 оны 9-10 дугаар сард 2,5 сая хувьцаа эзэмшигчид ногдол ашгаа хүлээн авлаа.

2020
Анхны хамтын хөрөнгө оруулалтын сан байгуулагдаж иргэд сангаар дамжуулан хөрөнгөө өсгөх боломж бүрдэв

УУЛ УУРХАЙН САЛБАР СЭРГЭХ БОЛОМЖТОЙ

Монгол Улсад 2020 оны төгсгөлд коронавирусын цар тахал дэгдсэнээс болж 2021 оны эхний хагаст бүтэн болон хэсэгчилсэн хөл хорио тавигдаж, цаашид ч үргэлжлэх магадлал өндөр.

Хэдийгээр коронавирусын эсрэг вакцин гарсан ч манай улсад цар тахлын 2, 3 дахь давлагаа үүсэх эрсдэл өндөр байгаа юм. Ингэснээр соёл урлаг, үзвэр, үйлчилгээ, аялал жуулчлал, зочид буудал, боловсрол гэх мэт салбарт үйл ажиллагааны хэсэгчилсэн хязгаарлалт дахин тавигдаж болзошгүй байна.

Тиймээс 2021 оны эхний хагаст зах зээл бүрэн сэргэх боломжгүй нөхцөл байдал үүсээд байгаа юм. Манай улсын хувьд коронавирусын эсрэг вакциныг оны эхний хагаст хүн амын эрсдэлтэй бүлэгт, хоёр дугаар хагаст хүн амын 60 орчим хувьд хийх магадлалтай байна.

Уул уурхайн салбарын хувьд, ногоон бүс хөтөлбөртэй холбоотойгоор 2021 оны эхний хагасаас сэргэж эхлэнэ. Хэдийгээр ажлын ээлж солих зэрэг хүндрэлтэй асуудал тулгарч байгаа ч уул уурхайн салбар өсөлтөө хадгалах боломжтой байна.

Салбаруудын сэргэх хандлага

Эдийн засгийн салбар	Өсөх боломж	2021*				2022*		
		Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	Q3
ХАА	Өндөр							
Уул уурхай	Дунджаас доогуур							
Хүнсний бус боловсруулах	Бага							
Хүнсний боловсруулах	Өндөр							
Цахилгаан	Өндөр							
Барилга	Бага							
Худалдаа	Өндөр							
Тээвэр	Дунджаас доогуур							
Мэдээлэл технологи	Өндөр							
Бусад үйлчилгээ	Дунд							
Дотоодын аялал жуулчлал	Бага							
Гадаадын аялал жуулчлал	Бага							
Боловсрол	Бага							
Санхүү, даатгал	Бага							

*Эх сурвалж: Голомт банк, УСХ, *таамаглал*

2021 ОНД ЭДИЙН ЗАСАГ 4 ОРЧИМ ХУВИАР ӨСӨХӨӨР БАЙНА

Азийн хөгжлийн банк, Монголбанк зэрэг байгууллага нь Монгол Улсын 2021 оны эдийн засгийг 6 орчим хувиар өснө гэж мэдээлсэн. Гэхдээ тус таамаглалыг хийхдээ "хөл хориогүй нөхцөл"-д байхуйцаар тооцоолжээ.

Гэвч бодит нөхцөл байдалд цар тахлын давлагаа 2021 оныг давах нь тодорхой байгаа юм. Тиймээс 2021 оны эхний хагаст хэсэгчилсэн хөл хорио үргэлжилнэ гэж үзвэл эдийн засаг 4 орчим хувиар өсөхөөр байна.

Үүнд уул уурхай түүнийг дагасан худалдаа, тээвэр, хүнсний салбарын өсөлт нөлөөлөх магадлал өндөр байгаа юм.

ХАНШ ТОГТВОРТОЙ БАЙХ ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙНА

Хэдийгээр импорт он гараад өсөхөөр байгаа ч экспортын хурдыг гүйцэж чадахгүй тул гадаад худалдааны тэнцлийн ашиг өндөр байхаар байна. Энэ нь эргээд төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлэх юм. Түүнчлэн, ирэх онд бондын томоохон төлөлт байхгүй учраас валютын гадагшаа чиглэсэн урсгал бага байхаар хүлээгдэж байна. Улмаар ханшийн огцом хэлбэлзэл үүсэхгүй.

Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл болон таамаглал

Секторуудын хувь нэмэр	2018	2019	2020				2021*
			I	I-II	I-III	I-IV*	
	Тогтвортой	Тогтвортой	Сөрөг	Сөрөг	Сөрөг	Сөрөг	
Эдийн засгийн өсөлт	7.2	5.2	-10.7	-9.7	-7.3	-5.3	4.0
ХАА	4.5	8.4	0.5	1.9	1.6	0.8	-
Уул уурхай	6.1	-0.4	-7.7	-6.2	-4.3	-2.0	-
Боловсруулах	15.7	10.9	0.2	-0.3	-0.4	-0.1	-
Цахилгаан	0.0	5.6	0.2	0.1	0.0	0.0	-
Барилга	4.7	8.0	0.1	-0.2	-0.2	-0.3	-
Худалдаа	2.2	7.9	-1.2	-1.5	-1.5	-1.3	-
Тээвэр	7.6	2.0	-2.1	-1.8	-1.5	-1.5	-
Мэдээлэл	7.8	7.5	0.0	0.0	0.0	0.0	-
Үйлчилгээ	4.8	5.8	0.2	-0.1	0.1	-0.2	-
БЦТ	20.1	5.4	-1.0	-1.6	-1.1	-1.1	-

*Эх сурвалж: Голомт банк, ҮСХ, *таамаглал*

ДОТООДЫН ОНЦЛОХ ХУВЬЦАА: АПУ ХК (MSE:APU)

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

Б.Тэлмэн
Хөрөнгө оруулалтын шинжээч,
telmen@golomtcapital.com

Хүснэгт 1: Хувьцааны арилжааны мэдээлэл	
03-р сарын 05, 2021	MSE:APU
Хаалтын ханш (2021.03.05):	750₮
52 долоо хоног:	512₮ – 748₮
Нийт хувьцааны тоо ширхэг:	1,064,181,553
Зах зээлийн үнэлгээ:	796,965,313,564

График 1: Хувьцааны арилжааны түүх



Эх сурвалж: МХБ

Хүснэгт 2. Харьцаа үзүүлэлтүүд	
Үнэ-ашгийн харьцаа (P/E)	**9.0**
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	**1.7**
Үнэ-хувьцааны харьцаа (P/S)	**1.6**
Ногдол ашгийн өгөөж	**13%**

Тодруулга: Хувьцааны ханшийг 2021 оны 03- сарын 05-ны өдрөөр, санхүүгийн үзүүлэлтийг 2020 оны жилийн тайланд үндэслэж тооцов.

Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК тооцоолол

График 2: Хувьцаа эзэмшигчид



Эх сурвалж: МХБ

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК нь 1924 оноос шингэн хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаагаа тууштай явуулж буй **Монголын ууган үйлдвэрлэгч компани** юм. Тус компани Чех улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар 1927 онд шар айраг үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд Монголын хамгийн анхны хар пивог 1940 онд үйлдвэрлэсэн байна. Эдүгээ тус компани нь долоон охин компанитай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК-ийн 56.09 хувийг Шунхлай Групп, 25.03 хувийг Heineken Asia pacific PTE LTD, 13.46 хувийг Steppe Beverage KFT тус тус эзэмшдэг. Мөн 5.42 хувийг олон нийтэд санал болгосон ба нийт 1,064,181,553 тоо ширхэг хувьцааг хөрөнгийн зах дээр арилжаалж байна.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

АПУ ХК нь нийт 2060 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж, 319 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын зах зээлд борлуулдаг. **АПУ ХК нь дотоодын согтууруулах ундааны зах зээлийн 78 хувийг, дотоодод үйлдвэрлэсэн шар айргийн зах зээлийн 93 хувийг дангаараа эзэлдэг.**

Согтууруулах ундааны бизнес: 2020 оны байдлаар нийт 16 брэндийн 74 нэр төрлийн архи, импортын 11 брэндийн виски болон бусад спиртийн төрлүүдийг дотоодын зах зээлд нийлүүлж байна.

Ус ундаа, шүүсний бизнес: 2020 оны байдлаар нийт 5 брэндийн 18 төрлийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нийлүүлж байна.

Брэнд: АПУ цэвэр ус, Оргилуун, Тэрэлж, Сэлэнгэ, Фрутта

Сүү, сүүн бүтээгдэхүүний бизнес: 2020 оны байдлаар нийт 32 төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Брэнд: Цэвэр сүү, Дээж, Маамуу, Сайн

Экспортын бизнес: 2020 оны байдлаар нийт 11 төрлийн согтууруулах ундааны бүтээгдэхүүнийг БНХАУ, ОХУ, БНСУ, Япон болон Европын холбооны улсуудад экспортолж байна. Экспортын борлуулалтын 55 хувийг БНХАУ-ын зах зээл бүрдүүлдэг.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

2020 оны санхүүгийн байдлыг өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад АПУ ХК-ийн борлуулалтын орлого 4 хувиар өсөж, 491 тэрбум төгрөгт, цэвэр ашиг 17 хувиар өсөж 89 тэрбум төгрөгт, нийт хөрөнгө 2 хувиар өсөж 556 тэрбум төгрөгт тус тус хүрсэн. Сүүлийн 4 жилд компанийн нийт хөрөнгө жилд дунджаар 18 хувиар , борлуулалтын орлого 24 хувиар, цэвэр ашиг 133 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Борлуулалтын орлого (тэрбум төг)

2016-2020 (CAGR 24%)



Цэвэр ашиг (тэрбум төг)

2016-2020 (CAGR 133%)



Нийт хөрөнгө (тэрбум төг)

2016-2020 (CAGR 18%)



Хөрөнгийн бүтэц



Санхүүжилтын бүтэц



Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол

ДОТООДЫН ОНЦЛОХ ХУВЬЦАА: ТҮМЭН ШУВУУТ ХК (MSE:TUM)

ТҮМЭН ШУВУУТ

Хүснэгт 1. Хувьцааны арилжааны мэдээлэл	
03-р сарын 05, 2021	MSE:TUM
Хаалтын ханш (2021.03.05):	220₮
52 долоо хоног:	130₮ - 232₮
Нийт хувьцааны тоо ширхэг:	200,000,000
Зах зээлийн үнэлгээ:	₮43,958,000,000

График 1. Хувьцааны арилжааны түүх

Эх сурвалж: МХБ

Хүснэгт 2. Харьцаа үзүүлэлтүүд	
Үнэ-ашгийн харьцаа (P/E)	11.0
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	1.7
Үнэ-хувьцааны харьцаа (P/S)	1.7
Ногдол ашгийн өгөөж	4%

Тодруулга: Хувьцааны ханшийг 2021 оны 03- сарын 05-ны өдрөөр, санхүүгийн үзүүлэлтийг 2020 оны жилийн тайланд үндэслэж тооцов.

Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК тооцоолол

График 2: Хувьцаа эзэмшигчид



Эх сурвалж: МХБ

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Түмэн Шувуут ХК нь 2004 онд 20,000 өндөглөгч тахиатайгаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Үүсгэн байгуулагдсан цагаас өнөөг хүртэл шувууны аж ахуйн үйл ажиллагааг тогтвортой эрхэлсэн салбартаа тэргүүлэгч компани юм. Тус компани нь хөдөө аж ахуйн цогц шийдлийг хэрэгжүүлэх зорилтынхоо хүрээнд махны чиглэлийн тахианы аж ахуй, малын тэжээлийн үйлдвэр, өндөгний сав баглааны үйлдвэр, органик бордооны үйлдвэр, усалгаатай газар тариаланг тус тус эрхэлж байна. Түмэн Шувуут ХК нь өндөгний зах зээлд тэлэх бодлого баримтлан өндөгний үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэхээр зорьж байна. Энэ бодлогын хүрээнд ТҮМЭН ШУВУУТ-2 төслийг хэрэгжүүлж, 2024 он гэхэд 7 өндөглөгчийн байр, 1 дэгдээхийний байр нэмж барихаар төлөвлөн ажиллаж байгаа юм.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц тогтвортой бөгөөд тус компанийн үүсгэн байгуулагч Л. Эрхэмбаяр, ТУЗ-ийн гишүүн Б. Тунгалаг нар нь тус тус 30 хувийг эзэмшдэг ба гүйцэтгэх захирал Ж.Болд, Гадаад харилцаа хариуцсан захирал Э.Баяржаргал нар нь тус бүр компанийн 7.5 хувийг эзэмшдэг байна.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2020 оны 12 дугаар сарын байдлаар тус компани нь 316,992 өндөглөгч тахиатай, 160 гаруй ажилтантайгаар Монгол Улсын дотоодын өндөгний үйлдвэрлэлийн 34 хувийг дангаар бүрдүүлэн ажиллаж байна.

- **Хүнсний өндөг:** Тус компани нь иодтой, өндөг, омега 3-тай өндөг, сувиллын өндөг, залуу тахианы өндөг, өглөөний өндөг гэсэн нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нийлүүлж байна.
- **Малын тэжээл:** Агро фийд малын тэжээлийн үйлдвэрт үйлдвэрлэсэн 6 нэр төрлийн бүтээгдэхүүнийг хөдөө орон нутгийн борлуулалтын цэгүүдээр дамжуулан борлуулж байна.
- **Бордоо:** 2020 оны 5 дугаар сард Түмэн Шувуут ХК нь 100 хувь органик бордооны үйлдвэрийг ашиглалтад оруулснаар зах зээлд шинэ бүтээгдэхүүн нийлүүлж эхэлсэн байна.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

2020 оны санхүүгийн байдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Түмэн Шувуут ХК-ийн борлуулалтын орлого 26 хувиар өсөж 25 тэрбум төгрөгт, цэвэр ашиг 24 хувиар өсөж 4 тэрбум төгрөгт, нийт хөрөнгө 31 хувиар өсөж 34 тэрбум төгрөгт хүрсэн. Сүүлийн 4 жилд компанийн нийт хөрөнгө жилд дунджаар 31 хувиар , борлуулалтын орлого 25 хувиар, цэвэр ашиг 48 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Борлуулалтын орлого (сая төг)

2016-2020 (CAGR 25%)



Цэвэр ашиг (сая төг)

2016-2020 (CAGR 48%)



Нийт хөрөнгө (сая төг)

2016-2020 (CAGR 31%)



Хөрөнгийн бүтэц



Санхүүжилтын бүтэц



Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол

ДОТООДЫН ОНЦЛОХ ХУВЬЦАА: МОНОС ХҮНС ХК (MSE:MFC)

МОНОС ХҮНС

Хүснэгт 1. Хувьцааны арилжааны мэдээлэл	
03-р сарын 05, 2021	MSE:MFC
Хаалтын ханш (2021.03.05):	70₮
52 долоо хоног:	60₮ - 79₮
Нийт хувьцааны тоо ширхэг:	408,850,428
Зах зээлийн үнэлгээ:	28,619,529,960

График 1. Хувьцааны арилжааны түүх

Тоо ширхэг
Нэгж хувьцааны үнэ

Эх сурвалж: МХБ

Хүснэгт 2. Харьцаа үзүүлэлтүүд	
Үнэ-ашгийн харьцаа (P/E)	28.3
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	2.2
Үнэ-хувьцааны харьцаа (P/S)	2.3
Ногдол ашгийн өгөөж	1%

Тодруулга: Хувьцааны ханшийг 2021 оны 03- сарын 05-ны өдрөөр, санхүүгийн үзүүлэлтийг 2020 оны жилийн тайланд үндэслэж тооцов.

Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК тооцоолол

График 2: Хувьцаа эзэмшигчид



Эх сурвалж: МХБ

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Эрүүл мэндийг дэмжигч хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монос Хүнс ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан Монос Группийн охин компаниудын нэг юм. Тус компани нь эрүүл мэндийн бэлдмэл, үрлэн чихэр, цай, цэвэр ус, жимсний шүүс гэсэн хүнсний бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нийлүүлдэг Монгол Улсын 21 аймгийн 7,000 гаруй цэгт бүтээгдэхүүнээ борлуулдаг байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Л. Хүрэлбаатар нь Монос Группийн үүсгэн байгуулагч бөгөөд Монос Хүнс ХК-ийн 70 хувийг эзэмшдэг. Компанийн 30 хувийг олон нийтэд санал болгосон ба нийт 408,850,428 тоо ширхэг хувьцааг хөрөнгийн зах дээр арилжаалж байна.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монос Хүнс ХК нь 180 гаруй ажилтантай, нийт 13 брэндийн 83 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Тус компанийн үйлдвэрлэдэг биологийн идэвхт бүтээгдэхүүнүүд нь дотоодын зах зээлд эрэлт өндөртэй юм.

Энхжин цай: Энхжин цайнд орсон ургамал тус бүрийг биологийн идэвхт бодисын агууламж хамгийн өндөр үед нь түүн бэлтгэж, тусгай технологиор боловсруулдаг тул өдөр бүр ууж хэрэглэснээр аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

ЭКОС ус: Ходоодны хүчил, шүлтийг тэнцвэржүүлэх үйлчилгээтэй pH 8.5-тай ЭКОС шүлтлэг, зөөлөн усыг Монголчуудын эртнээс амьдрал ахуйдаа ашиглаж ирсэн хужираар баяжуулсан бөгөөд ходоодны үрэвсэл, улайлт, шархны эдгэрэлтийг түргэсгэх, хүчил шүлтийн балансыг тэнцвэржүүлэхэд тустай.

Берривит: Монгол Улсын хөрсөнд ургадаг байгалийн зэрлэг жимс болох аньс, нэрс, чацаргана жимсэнд агуулагдах аминдэм, эрдэс бодисуудыг хүүхэд багачууддаа зориулан витаминт, үзэмтэй, ааруултай гэсэн нэр төрлийн үрлийг үйлдвэрлэдэг байна.

Витос (Цэнэг): Эрүүл мэндийн бэлдмэл нь олон төрлийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмчилгээний үр дүнд эерэгээр нөлөөлөх онцгой ач холбогдолтой юм.

Экспортын бизнес: Япон улсад Эко уусдаг цай, БНХАУ-д бүх бүтээгдэхүүнээ, АНУ-д 48 нэр төрлийн бүтээгдэхүүнээ экспортолдог.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Монос Хүнс ХК-ийн 2020 оны санхүүгийн байдлыг өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад борлуулалтын орлого 32 хувиар өсөж 12 тэрбум төгрөгт, цэвэр ашиг 22 хувиар өсөж 1 тэрбум төгрөгт, нийт хөрөнгө 8 хувиар буурч 19 тэрбум төгрөгт тус тус хүрсэн. Сүүлийн 4 жилд компанийн нийт хөрөнгө жилд дунджаар 38 хувиар , борлуулалтын орлого 35 хувиар, цэвэр ашиг 22 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Борлуулалтын орлого (сая төг)

2016-2020 (CAGR 35%)



Цэвэр ашиг (сая төг)

2016-2020 (CAGR 22%)



Нийт хөрөнгө (сая төг)

2016-2020 (CAGR 38%)



Хөрөнгийн бүтэц



Санхүүжилтын бүтэц



Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол

ДОТООДЫН ОНЦЛОХ ХУВЬЦАА: МАНДАЛ ХК (MSE:MNDL)

Хүснэгт 1. Хувьцааны арилжааны мэдээлэл	
03-р сарын 05, 2021	MSE:MNDL
Хаалтын ханш (2021.03.05):	64.6₮
52 долоо хоног:	38.88₮ - 69.94₮
Нийт хувьцааны тоо ширхэг:	624,301,600
Зах зээлийн үнэлгээ:	40,329,883,360

График 1. Хувьцааны арилжааны түүх

Эх сурвалж: МХБ

Хүснэгт 2. Харьцаа үзүүлэлтүүд	
Үнэ-ашгийн харьцаа (P/E)	8.8
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	1.8
Үнэ-хувьцааны харьцаа (P/S)	2.4
Ногдол ашгийн өгөөж	4.5%

Тодруулга: Хувьцааны ханшийг 2021 оны 03-сарын 05-ны өдрөөр, санхүүгийн үзүүлэлтийг 2020 оны жилийн тайланд үндэслэж тооцов.

Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК тооцоолол

График 2. Хувьцаа эзэмшигчид



Эх сурвалж: МХБ

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Мандал Даатгал ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан. Тус компани нь Монгол Улсын даатгалын салбарт шинэ өнгө төрх нэмэн, даатгалын суурь систем нэвтрүүлэх замаар өөрсдийн байр суурьиа нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байна. Уг компани нь 22 хэлбэрийн эрсдэлийг даатгах 52 төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг харилцагчдадаа санал болгодог юм. 2020 онд олон улсын санхүүгийн зэрэглэл тогтоодог AM Best агентлагаас ерөнхий санхүүгийн чадавхи "B", урт хугацааны зээлжих зэрэглэл "BB+" буюу цаашдын төлөвийг "Тогтвортой" гэх үнэлгээг авчээ.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Мандал Даатгал ХК-ийн 41 хувийг Голомт Файнэншил Групп ХХК, 37 хувийг Юу Эм Си Капитал ХХК эзэмшдэг. Мөн 23 хувийг олон нийтэд санал болгосон ба нийт 624,301,600 тоо ширхэг хувьцааг хөрөнгийн зах дээр арилжаалж байна.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мандал Даатгал ХК нь Иргэдийн болон Байгууллагын гэсэн үндсэн 2 чиглэлд нийт 126 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж, 52 нэр төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд борлуулдаг. Мандал Даатгал ХК нь 2020 оны байдлаар мөнгөн хөрөнгө, цэвэр ашгийн хэмжээгээр салбартаа тэргүүлсэн байна.

- **Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал:** Иргэд, гэр бүлийн эрүүл мэнд, гадаад болон дотоодод аялж буй хүмүүст зориулсан даатгал
- **Барилга угсралтын даатгал:** Эд хөрөнгө, ажилчдыг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалсан даатгал
- **Авто тээврийн хэрэгслийн даатгал:** Иргэд болон байгууллага дээр бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд учирч болох гэнэтийн осол эрсдэлээс хамгаалсан даатгал
- **Хөрөнгийн даатгал:** Иргэн болон ААН-үүдийн эзэмшиж буй биет хөрөнгийг хамгаалсан даатгал
- **Хариуцлагын даатгал:** ААН-ээс хамааралтай гуравдагч этгээд болон үйлчлүүлэгчид хохирол учирсан, ажил олгогчоос хамааралтай эрсдэл болон даатгуулагчийн мэргэжилтэй холбоотой алдаанаас хамгаалсан даатгал
- **Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал:** Авто тээврийн хэрэгсэл жолоо барих албан журмын даатгал
- Бусад

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

2020 оны санхүүгийн байдлыг өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад Мандал Даатгал ХК-ийн нийт хураамжийн орлого 15 хувиар өсөж 33 тэрбум төгрөгт, цэвэр ашиг 22 хувиар буурч 4 тэрбум төгрөгт, нийт хөрөнгө 16 хувир өсөж, 47 тэрбум төгрөгт хүрсэн. Сүүлийн 4 жилд компанийн нийт хөрөнгө жилд дунджаар 29 хувиар, борлуулалтын орлого 26 хувиар, цэвэр ашиг 160 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Б.Дөлгөөн-Од
Хөрөнгө оруулалтын шинжээч,
dulguun-od@golomtcapital.com

Борлуулалтын орлого (тэрбум төг)

2016-2020 (CAGR 26%)



Цэвэр ашиг (тэрбум төг)

2016-2020 (CAGR 160%)



Нийт хөрөнгө (тэрбум төг)

2016-2020 (CAGR 29%)



Хөрөнгийн бүтэц



Санхүүжилтийн бүтэц



Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол

ДОТООДЫН ОНЦЛОХ ХУВЬЦАА: ИНВЕСКОР ББСБ ХК (MSE:INV)

InvesCore

Хүснэгт 1. Хувьцааны арилжааны мэдээлэл	
03-р сарын 05, 2021	MSE:INV
Хаалтын ханш (2021.03.05):	3,299₮
52 долоо хоног:	2,401₮ – 3,316₮
Нийт хувьцааны тоо ширхэг:	71,727,918
Зах зээлийн үнэлгээ:	236,630,401,482₮

График 1. Хувьцааны арилжааны түүх

■ Тоо ширхэг
— Нэгж хувьцааны үнэ

Эх сурвалж: МХБ

Хүснэгт 2. Харьцаа үзүүлэлтүүд	
Үнэ-ашгийн харьцаа (P/E)	**19.4**
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	**4.5**
Үнэ-хувьцааны харьцаа (P/S)	**9.2**
Ногдол ашгийн өгөөж	**0.5%**

Тодруулга: Хувьцааны ханшийг 2021 оны 03- сарын 05-ны өдрөөр, санхүүгийн үзүүлэлтийг 2020 оны жилийн тайланд үндэслэж тооцов.

Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК тооцоолол

График 2: Хувьцаа эзэмшигчид



Эх сурвалж: МХБ

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Инвескор ББСБ ХК нь 2016 оны 3 дугаар сарын 29-ний өдөр үүсгэн байгуулагдаж, 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. Уг ББСБ нь Монгол Улсын банк бус санхүүгийн салбарт уламжлалт үйлчилгээг финтек буюу технологид суурилсан үйлчилгээтэй хослуулан хүргэдэг. Тиймээс ч өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаа нь хурдацтай өсөж, шинэлэг шуурхай үйлчилгээгээр харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг ханган ажиллаж байна. Эдүгээ тус компани нь Инвескор Эй Ай Лаб ХХК болон Инвескор хэтэвч ХХК гэх 2 охин компанитай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Инвескор ББСБ ХК-ийн 85 хувийг Эс Ай Би Жэй Капитал ХХК эзэмшдэг. Харин 15 хувийг олон нийтэд санал болгосон ба нийт 71,727,918 тоо ширхэг хувьцааг хөрөнгийн зах зээл дээр арилжаалж байна. Эс Ай Би Жэй Капитал ХХК-ийн 45 хувийг Баянмөнхийн Анхболд, 31 хувийг Батбаярын Мөнх-Очир, 24 хувийг Кавазоэ Такааки тус тус эзэмшдэг.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Инвескор ББСБ ХК нь Улаанбаатар хотод ББСБ-ын чиглэлээр 12 салбар, Эрдэнэт хотод 1 салбар, Япон болон Киргиз улсуудад салбар компанитайгаар үйл ажиллагаа явуулж байна.

- **Зээлийн үйл ажиллагаа:** 2020 оны байдлаар хэрэглээний, автомашины, бизнесийн болон бизнесийн шугам гэсэн нийт 4 төрлийн барьцаат зээлийн бүтээгдэхүүн харилцагчдадаа санал болгож байна.
- **Итгэлцлийн үйл ажиллагаа:** Иргэд болон ААН-үүдэд зориулсан хугацаатай хуримтлал үүсгэх боломжийг санал болгодог.
- **Бичил зээлийн үйл ажиллагаа:** Богино хугацаатай бага дүнтэй бичил зээлийг Pocket аппликейшнээр дамжуулан финтек буюу технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг.
- **Төлбөрийн баталгаа:** Харилцагчдадаа төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээг үзүүлдэг.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

2020 оны санхүүгийн байдлыг өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад Инвескор ББСБ ХК-ийн хүүгийн орлого 33 хувиар өсөж 26 тэрбум төгрөгт, цэвэр ашиг 41 хувиар өсөж 12 тэрбум төгрөгт, нийт хөрөнгө 70 хувиар өсөж 139 тэрбум төгрөгт тус тус хүрсэн. Сүүлийн 3 жилд компанийн нийт хөрөнгө жилд дунджаар 91 хувиар, борлуулалтын орлого 77 хувиар, цэвэр ашиг 67 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Борлуулалтын орлого (тэрбум төг)

2016-2020 (CAGR 77%)



Цэвэр ашиг (тэрбум төг)

2016-2020 (CAGR 67%)



Нийт хөрөнгө (тэрбум төг)

2016-2020 (CAGR 91%)



Хөрөнгийн бүтэц



Санхүүжилтын бүтэц



Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2021 ОНЫ ТӨЛӨВ

2021 ОНЫГ ХУВЬЦАА БА БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ ӨНГӨЛНӨ

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монголын хөрөнгийн зах зээл нь төрийн цогц бодлого, төлөвлөлтгүйгээр хөгжиж ирлээ. Тиймээс Монгол Улсын санхүүгийн салбар бүхэлдээ сонгодог утгаараа хөгжөөгүй эмзэг хэвээр байна. 2020 онд Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 3 их наяд төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 14 хувиар өссөн ч бусад улстай харьцуулахад сул хөгжилтэй хэвээр байна.

М.Мөнхтуяа
Хөрөнгө оруулалтын ахлах шинжээч,
munkhtuya@golomtcapital.com

ДНБ-нд эзлэх хөрөнгийн зах зээлийн хувь хэмжээ /2019 он/



Эх сурвалж: Дэлхийн банк

Монгол Улсын ДНБ-нд эзлэх хөрөнгийн зах зээлийн хувь хэмжээ



Эх сурвалж: YCX

Манай улсын эдийн засаг банк төвтэй, хөгжлийн ганц тулгууртай байсан гэхэд хилсдэхгүй. Мөн хадгаламжийн хүү өндөр байсан нь иргэд, ААН-үүдийг хөрөнгийн зах зээлд мөнгө байршуулах, хөрөнгө оруулалт хийх сонирхлыг нь хааж байсан юм.

Тэгвэл 2021 онд Ковид 19-ийн нөлөөгөөр харилцах дансанд тооцох хүү 0 хувь, мөнгөний бодлогын хүү 6 хувь, банкуудын хадгаламжийн төгрөгийн жигнэсэн дундаж хүү 7.9 хувь, ам.долларын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2 хувь болж буурснаар нөхцөл байдал огцом эргэлээ.

Хүүний түвшин, хувиар



Эх сурвалж: Монголбанк

Энэхүү нөхцөл байдал дунд хугацаанд ч үргэлжлэх нь тодорхой байгаа тул иргэд, ААН-үүд өөрийн мөнгөн хөрөнгийг хэрхэн найдвартай, өгөөжтэйгээр өсгөх вэ? гэсэн асуудалтай тулгарч байна.

Тиймээс яг энэ цаг үе бол дотоодын болон гадаадын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх боломж юм.

МОНГОЛД БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ ХӨГЖИХ АЛТАН ҮЕ ИРЭЭД БАЙНА

Монгол Улсын банкны салбарт 2021 оны 1 дүгээр сарын байдлаар нийт 36.4 их наяд төгрөг байна. Үүний 5 их наяд төгрөг нь харилцах дансанд, 4.2 их наяд төгрөг нь хугацаагүй хадгаламжинд, 13.3 их наяд төгрөг нь хугацаатай хадгаламжинд байршиж байгаа юм.

Хадгаламжийн хүү буурснаар дээрх мөнгөн хөрөнгө хөдөлгөөнд орох нөхцөл бүрдсэн ч санхүүгийн ямар хэрэгсэлд байршуулах, хэрхэн өндөр өгөөж хүртэх вэ? гэсэн асуудал иргэдийн хувьд тодорхойгүй байна.

Харин шинжээчдийн зүгээс Монгол Улсад хөрөнгийн зах зээл бүрэн утгаараа хөгжөөгүй байгаа энэ үед хамгийн эрсдэл багатай, найдвартай сонголт бол "БОНД" гэсэн дүгнэлтийг санал нэгтэйгээр өгч байна.

Голомт Капитал ҮЦК ХХК-ийн шинжээчдийн хувьд бондын хөрөнгө оруулалтын эрсдэл, өгөөжийг дараах гурван түвшинд ангилж байна.

1. **Барьцаат бонд**
   Хүү өндөр ч бонд дефолт болвол барьцааг худалдах замаар төлбөрийг буцаан олгоно. Дефолт болсон тохиолдолд процессын хувьд олон шат дамжлага үүсэх тул уг төрлийн бондод хөрөнгө оруулалт хийхдээ болгоомжтой байх хэрэгтэй.

2. **Даатгалтай бонд**
   Бонд гаргагч нь бондын эргэн төлөлтийг хийх боломжгүй болсон тохиолдолд даатгалын компани төлбөрийг олгоно. Үйл явц нь өмнөх бондтой харьцуулахад хялбар ч даатгалын гэрээний зүйл заалтыг нарийвчлан шинжлэхгүй бол нөхөн төлбөр олгогдохгүй байх магадлалтай байдаг.

3. **Банкны баталгаат бонд**
   Хэрэв бонд дефолт болвол баталгаа гаргасан банк төлбөрийг төлнө. Банк өөрөө дампуурлын эрсдэлд ороогүй бол бондын эргэн төлөлт хамгийн хурдан, хялбар хийгддэг.

Жишээ нь:
Голомт Капитал ҮЦК ХХК нь Голомт банкны баталгаатай жилийн 15 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай, 1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Нөмөр хаалттай бондыг 2020 оны 9 дүгээр сард амжилттай хэрэгжүүлсэн билээ.

Энэ нь дотоодын компаниудад бондын зах зээлд хөл тавьж, урт хугацааны өртөг багатай санхүүжилтийг босгох боломжийг өгсөн юм. Харин хөрөнгө оруулагчдын хувьд хувьцаатай харьцуулахад эрсдэл багатай, хадгаламжаас өндөр хүүтэй хөрөнгө оруулалт хийх боломжийг олгосон.

Хувьцаагаарх санхүүжилтээс ялгаатай нь компанийн бонд нь одоогийн хувьцаа эзэмшлийн бүтцэд өөрчлөлт оруулахгүйгээр санхүүжилт босгон, процессын хувьд хурдан хугацаанд хялбар хийгдэх боломжтойгоороо онцлогтой байдаг.

ВАЛЮТЫН ХАДГАЛАМЖАА БОНД РУУ ХӨРВҮҮЛЖ, ӨНДӨР ӨГӨӨЖ ХҮРТЭХ БОЛОМЖ

Монголын банкны салбар дахь валютын хадгаламжийн хүү буурсан, ам.долларын ханш төгрөгийн эсрэг тогтвортой, валютын зах зээлийн суурь үзүүлэлтүүд сайн байгаа нь цаашид ч ам.долларын ханш тогтуун байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Энэхүү шалтгааны улмаас банкны валютын хадгаламж 2020 оны төгсгөлд 65 орчим сая ам.доллараар огцом буурч, цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна.

Тиймээс та зөвхөн дотоодын гэлтгүй олон улсын бондуудад хөрөнгө оруулж, банкны хадгаламжаас өндөр өгөөж хүртэх боломжтой юм.

Уг бондууд нь ихэвчлэн улс орнуудын засгийн газар болон томоохон компани, корпорациудын гаргасан валютын бондууд байдаг.

Э.Мишээл
Форэйкс трэйдэр,
misheel@golomtcapital.com

Бондын хувьд үнэ нь хувьцааны нэгэн адилаар тогтмол хэлбэлзэж байдаг. Харин бондын үнэ өсөхөд өгөөж нь буурч, үнэ буурах үед өгөөж өсдөг зүй тогтолтой. Тиймээс бондын үнэ буурч өгөөж өсөх үед буюу зөв цагт нь хөрөнгө оруулалт хийснээр өндөр ашиг хүртэх боломжтой юм.

Өүлэн бондын үнэ, ам.долларaар



Жишээлбэл, 2020 оны 5 дугаар сард Монголын Ипотекийн Корпорациас гаргасан Өүлэн бондын үнэ 75.09 болсноор өгөөж нь оргил үедээ 29.77 хувьд хүрсэн. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулагч энэ үед тус бондыг худалдан авсан бол ам.доллар дээр жилийн 30 хувийн өгөөж хүртэх боломжтой байсан юм.

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСАНД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ БОЛОМЖ НЭЭГДЭЖ БАЙНА

Цаашид хөгжих ирээдүйтэй шинэлэг бүтээгдэхүүн бол хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас юм.

Бондтой харьцуулахад эргэн төлөгдөх мөнгөн урсгал нь үе тутамд өндөр тул хөрвөх чадвар илүү сайн байдаг. Мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь компанийн дампуурлаас ангид тул үйл ажиллагаанаас нь шалтгаалах эрсдэл багатай юм.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ард буй хөрөнгийн багц нь ихэвчлэн тараан байршсан олон хөрөнгөөс бүрддэг. Тиймээс нэг төрлийн хөрөнгөөс хамаарах эрсдэлийг бууруулж өгдөг.

Тиймээс хувьцаатай харьцуулахад эрсдэл бага, тогтмол өгөөжтэй санхүүгийн хэрэгсэл 2021 оноос хөрөнгийн зах зээлд нэвтрэх эдийн засгийн суурь нөхцөл бүрдээд байна.

Энэ нь иргэдэд өөрсдийн мөнгийг хадгаламжаас өндөр хүүтэйгээр өсгөх, компаниудад өртөг багатай санхүүжилт босгох боломжийг нээх юм.

ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛД ШИНЭ ДАВЛАГАА ҮҮСЛЭЭ

М.Мөнхтуяа
Хөрөнгө оруулалтын ахлах шинжээч,
munkhtuya@golomtcapital.com

Хувьцааны зах зээл нь тогтмол өгөөжтэй бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай харьцуулахад эрсдэл өндөртэй ч өндөр өгөөж хүртэх боломжийг олгодог.

2020 оны байдлаар Монголын Хөрөнгийн Биржид (МХБ) нийт 65.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн. Үүний 82 хувь буюу 53.9 тэрбум төгрөгийн арилжааг хувьцааны арилжаа дангаар эзэлсэн байна.

МХБ-ийн арилжааны дүн, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Ковид 19 цар тахлын нөлөөгөөр үүссэн эдийн засгийн хямрал нь дотоодын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

Харин эдийн засгийн шоконд өртөх магадлал багатай, хүнсний салбарын компаниудын хувьд эерэг нөлөө үзүүллээ.

Тодруулбал, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн IPO андеррайтераар нь ажилласан Түмэн Шувуут ХК-ийн 2020 оны санхүүгийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй нь харьцуулахад, борлуулалтын орлого нь 26 хувиар, цэвэр ашиг нь 24 хувиар өссөн байна. Харин Монос Хүнс ХК-ийн борлуулалтын орлого 32 хувиар, цэвэр ашиг нь 33 хувиар тус тус өсчээ.

Ковид 19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямрал нь Түмэн Шувуут ХК-ийн бүтээгдэхүүний эрэлтийг зах зээлд мэдрүүлснээр тус компанийн тогтвортой байдал, ирээдүйн өсөх боломжид хөрөнгө оруулагчдын итгэх итгэлийг нэмэгдүүлсэн. Тус компанийн хөрөнгө оруулагчид 2021 оны эхний 1 сарын хугацаанд 24 хувийн өгөөж хүртсэн юм.

Өөрөөр хэлбэл, хувьцаат компаниудын үйл ажиллагаа явуулж буй салбар, бизнесийн стратеги, санхүүгийн болон үйл ажиллагааны тогтвортой байдал, болзошгүй эрсдэл зэргийг сайтар судалж хувьцаанд хөрөнгө оруулах нь хадгаламжийн хүүнээс өндөр өгөөжийг богино хугацаанд хүртэх боломжийг олгодог.

Гэхдээ та өгөөж байгаа л бол эрсдэл заавал дагадгийг санаж, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн санхүүгийн ухаалаг шийдвэр гаргах нь зөв юм.

БАНКНЫ РЕФОРМ НЬ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОЛОН ТУЛГУУРТ ХӨГЖЛИЙН ҮНДСИЙГ ТАВИЛАА

Монгол Улсын санхүүгийн зах зээл нь өнөөг хүртэл банк төвтэй буюу хэт хамааралтай үйл ажиллагаа явуулж ирсэн. УИХ-аас 2021 оны 1 дүгээр сарын 29-нд Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталснаар санхүүгийн зах зээлийн олон тулгуурт хөгжлийн үндэс тавигдлаа.

Уг шинэчлэлийн дагуу Банкны тухай хуулийн 15 хувьд нь өөрчлөлт хийгдсэн юм. Тодруулбал, банкны засаглалыг сайжруулах, хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бууруулах, нээлттэй ХК болгон хэлбэрийг өөрчлөх замаар олон хувьцаа эзэмшигчтэй болгох, нэг хувьцаа эзэмшигчийн эзэмших дээд хязгаарыг 20 хувиар тогтоох зэрэг өөрчлөлтийг оруулаад байна.

Банкны салбарын төвлөрлийг бууруулахын тулд нэг хувьцаа эзэмшигчийн эзэмших дээд таазыг хязгаарлах бодлого нь зөвхөн Монгол Улс гэлтгүй дэлхийн бусад улс орнуудад хэрэгждэг. Тухайлбал, Канадад нэг хувьцаа эзэмшигчийн тааз 20 хувь, Сингапурт 5 хувь, Энэтхэгт 60 хувь, Казахстанд 10 хувь тус тус байдаг юм.

Банкны реформ хийгдсэнээр:

1. Хөрөнгийн зах зээлд чанартай бүтээгдэхүүн бий болж, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, санхүүгийн хүртээмж дээшилнэ.

   2021 оны 1 дүгээр сарын байдлаар банкны салбарын нийт хөрөнгө 36.4 их наяд төгрөг, өөрийн хөрөнгө 3.1 их наяд төгрөг байна.

   Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2020 оны байдлаар 3 их наяд төгрөг байна. Банкууд IPO хийснээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2 дахин өсөх боломжтой юм. Энэ хирээр гадаадын болон дотоодын мөнгөн урсгал нэмэгдэнэ гэсэн үг юм.

   Хамгийн гол нь Монгол хүн бүр их наядаар хэмжигдэх хөрөнгө бүхий банкуудын хувьцаа эзэмшигч болох боломж нээгдэж байна. Улмаар ашигт ажиллагаанаас нь өгөөж хүртсэнээр, санхүүгийн хүртээмж нэмэгдэж, баялгийн тэгш хуваарилалт урт хугацаанд бий болох үр нөлөөтэй юм.

2. Банкны салбарын хэт төвлөрөл буурч, санхүүгийн зах зээлд олон тулгуурт хөгжил бий болно. 2020 оны байдлаар Монгол Улсын санхүүгийн салбарын 87.2 хувийг банкны салбар, 6.4 хувийг хөрөнгийн зах зээл бүрдүүлж байна. Гэтэл бусад хөгжингүй орнуудад хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь банкны активыг давдаг.

   Банкны реформ хийгдсэнээр харилцагчид зөвхөн банкинд мөнгөө хадгалуулах бус хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэнэ. Ингэснээр банкнаас хэт их хамааралтай санхүүгийн зах зээлийг задалж, хөрөнгийн зах зээл хөгжих нөхцөл бүрдэх юм.

3. Тэтгэврийн сан, Хөрөнгө оруулалтын сан зэрэг мэргэжлийн институциональ хөрөнгө оруулагчдын орон зай нэмэгдэнэ.

   Олон улсад топ банкуудын голлох хувьцаа эзэмшигчид нь мэргэжлийн институциональ хөрөнгө оруулагчид байдаг. Жишээлбэл, 2020 оны байдлаар дэлхийн топ банкууд болох JP Morgan Chase & Co, Goldman Sachs, Wells Fargo банкуудын хамгийн том хувьцаа эзэмшигчид нь Vanguard, SSgA, Blackrock зэрэг хөрөнгө оруулалтын сангууд юм.

   Иймд банкны реформ нь хөрөнгийн зах зээлд институциональ хөрөнгө оруулагчид бий болоход томоохон түлхэц болж байна. Уг тоглогчид хөрөнгийн зах зээлд орж ирснээр зах зээлд үнэ цэнийн хөрөнгө оруулалт бий болж, урт хугацааны тогтвортой байдал хангагдах юм.

ТОП 5 БАНКНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛТҮҮД

ХААН БАНК

Салбарын тоо:	Ажилтны тоо:	Нийт хөрөнгийн хэмжээ:	Нийт хөрөнгийн хэмжээгээр банкны салбарт эзлэх хувь:
551	6,300	12.1 их наяд төгрөг	33.1%

TDB

Салбарын тоо:	Ажилтны тоо:	Нийт хөрөнгийн хэмжээ:	Нийт хөрөнгийн хэмжээгээр банкны салбарт эзлэх хувь:
97	2,290	8.1 их наяд төгрөг	22.2%

ГОЛОМТ БАНК

Сайн сайхны санхүүжүүлэгч

Салбарын тоо:	Ажилтны тоо:	Нийт хөрөнгийн хэмжээ:	Нийт хөрөнгийн хэмжээгээр банкны салбарт эзлэх хувь:
104	2,400	7.2 их наяд төгрөг	19.6%

ХАСБАНК

Салбарын тоо:	Ажилтны тоо:	Нийт хөрөнгийн хэмжээ:	Нийт хөрөнгийн хэмжээгээр банкны салбарт эзлэх хувь:
78	1,200	3.2 их наяд төгрөг	8.8%

ТӨРИЙН БАНК

Салбарын тоо:	Ажилтны тоо:	Нийт хөрөнгийн хэмжээ:	Нийт хөрөнгийн хэмжээгээр банкны салбарт эзлэх хувь:
495	4,000	3.5 их наяд төгрөг	9.5%

Монгол Улсын арилжааны банкуудын үзүүлэлтүүд /2020 он/

Голлох үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр	Хаан	ХХБ	Голомт	Хас	Төрийн	Капитрон	Транс	Чингис Хаан	Кредит	Богд	Үндэсний хөрөнгө оруулалт	Ариг
Балансын үзүүлэлтүүд												
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,838.7	1,323.8	1,948.8	365.9	1,002.2	345.0	108.6	0.5	116.1	87.9	2.0	1.7
Зээл (цэвэр дүнгээр)	4,973.0	4,032.1	2,943.0	1,329.3	1,765.9	582.3	216.7	214.7	134.8	101.2	29.6	24.7
Чанаргүй зээл	351.3	572.0	258.7	90.5	189.3	44.9	5.2	46.8	0.2	3.8	84.5	-
Нийт хөрөнгийн дүн	12,151.8	8,158.5	7,211.2	3,236.7	3,492.6	1,129.6	360.3	325.9	254.1	222.4	101.3	60.7
Харилцах	1,697.4	1,239.2	1,412.2	396.3	334.6	196.1	9.8	162.5	1.9	18.7	112.7	1.4
Хадгаламж	7,426.3	3,753.7	3,648.1	1,629.3	2,333.0	596.0	78.1	57.6	81.4	64.2	27.1	28.0
Өр төлбөрийн дүн	10,876.0	7,091.1	6,624.4	2,965.8	3,179.3	1,017.2	251.1	318.0	201.5	161.0	175.4	35.9
Хувь нийлүүлсэн хөрөнгө	58.1	72.7	68.0	55.3	133.9	86.0	100.0	42.7	50.1	50.0	35.1	35.0
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,069.5	540.7	201.9	166.7	128.3	19.1	9.0	(35.6)	2.5	11.0	(113.4)	(10.5)
Өөрийн хөрөнгийн дүн	1,275.8	1,067.3	586.9	270.8	313.3	112.5	109.1	7.8	52.5	61.4	(74.0)	24.7
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	12,151.8	8,158.5	7,211.2	3,236.7	3,492.6	1,129.6	360.3	325.9	254.1	222.4	101.3	60.7
Орлогын үзүүлэлтүүд												
Хүүгийн орлого	1,116.7	770.1	571.0	365.4	373.3	94.0	44.7	29.0	28.0	24.2	2.9	7.3
Хүүгийн зардал	703.6	559.4	434.5	261.4	234.0	68.4	25.1	16.3	15.6	11.5	8.0	4.2
Хүүгийн цэвэр орлого	413.0	210.7	136.5	104.0	139.3	25.6	19.6	12.7	12.4	12.7	(5.0)	3.0
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	353.9	139.3	19.5	79.8	122.9	15.7	11.6	8.8	4.3	12.0	(7.2)	(6.8)
Бусад орлого	261.3	304.2	154.3	32.9	37.3	14.1	3.7	1.8	7.4	5.2	88.8	122.9
Бусад зардал	400.7	384.9	194.1	79.5	112.4	-	9.2	9.6	8.1	10.7	69.4	124.7
Татварын дараах ашиг, алдагдал	164.6	58.3	(23.0)	25.0	37.9	8.5	5.5	(0.1)	3.0	5.9	12.2	(8.4)
Монголбанкны журмын дагуух зохистой шалгуур үзүүлэлтүүд												
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа >9%	18.2%	15.6%	13.8%	16.9%	13.3%	12.5%	37.5%	1.0%	29.6%	41.4%	-57.5%	52.3%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа >12%	18.9%	17.2%	14.2%	17.4%	16.1%	12.9%	37.5%	1.1%	29.6%	41.4%	-57.5%	52.5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт >20%	57.2%	39.3%	40.2%	54.9%	39.0%	40.3%	28.5%	-11.6%	29.1%	59.0%	1.2%	64.1%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа +-15%	-5.1%	-12.7%	13.2%	-1.8%	13.0%	4.6%	-9.4%	-55.5%	5.6%	0.4%	8.4%	13.4%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа +-30%	-5.1%	-13.9%	26.2%	-4.2%	14.9%	5.6%	-9.4%	-66.2%	7.0%	1.0%	13.7%	15.1%

Жич: Уг үзүүлэлтүүд нь аудитлагдаагүй тайлангийн дүнгүүд болно.

Эх сурвалж: Банкуудын албан ёсны вэбсайт

БИД ТАНД ЮУ ӨГЧ ЧАДАХ ВЭ?

БРОКЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Голомт Капитал ҮЦК ХХК нь харилцагчдаа Монголын болоод олон улсын хөрөнгийн биржийн арилжаанд оролцож, өөрийн хөрөнгийг амжилттай удирдахад нь үнэнч туслагч байж ирсэн.

Бид харилцагчдаа оновчтой шийдвэр гаргахад нь туслах зорилгоор зөв цагт, зөв мэдээлэл, судалгааг өгөхийн тулд Арилжаа Судалгааны Хэлтэс болон Андеррайтерийн Хэлтэстэй нягт хамтран ажилладаг.

Бид өөрсдийн бэлтгэсэн дэлхийн болон дотоодын зах зээл, онцлох салбар, компаниудын талаарх судалгааг харилцагчдадаа хүргэхийн тулд онлайн уулзалтыг зохион байгуулахаас гадна биечлэн зөвлөгөө өгч, цахим хуудсаараа мэдээлж ажилладаг. Мөн харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилготой анхан, дунд, ахисан түвшний сургалтыг тогтмол зохион байгуулж ирлээ.

А.Ерболат
Ахлах брокер,
erbolat@golomtcapital.com

ДОТООДЫН ҮНЭТ ЦААСНЫ БРОКЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Голомт Капитал ҮЦК ХХК нь Монголын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцож, хөрөнгө оруулалт хийх боломжийг харилцагчдадаа олгодог. Та манай компаниар дамжуулан Монголын хөрөнгийн зах зээлийн арилжаанд онлайнаар оролцох боломжтой. Та бүх удирдлагыг гартаа авснаар тив дэлхийн хаана ч байсан хүссэн үедээ хөрөнгө оруулалт хийж, мөнгөө татах, мэдээлэл, судалгаатай танилцаж болно.

Тухайлбал, та өөрийн хөрөнгө оруулсан багцыг дараах байдлаар хяналтын самбар дээр инфографикаар харах боломжтой.

Түүнчлэн та дотоодын хувьцааны арилжааны бодит ханшийг цаг алдалгүй харах боломжтой.



Мөн та хувьцааны захиалгаа түргэн шуурхай оруулж арилжаанд оролцох боломжтой юм.

Та дансаа нээлгэж арилжаанд оролцохоосоо өмнө хамгийн чухал алхам болох судалгаа, шинжилгээ, мэдээлэлтэй танилцан шийдвэрээ гаргаарай. Бид таныг оновчтой шийдвэр гаргахад тань үргэлж хамт байж туслах болно.

ҮНЭТ ЦААСНЫ ДАНСАА ХЭРХЭН НЭЭЛГЭХ ВЭ?

1. ОНЛАЙН ВЕБ САЙТ-ЫН ХОЛБООСООР ДАМЖИН ДАНСАА НЭЭЛГЭХ

Монгол Улсын иргэн бүр /насанд хүрсэн, хүрээгүй/ нээлгэх боломжтой.

Данс нээх алхам

1. Данс нээх хэсэгт өөрийн мэдээллүүдээ үнэн зөв бүрэн бөглөнө
2. Иргэний үнэмлэхний урд болон ард талын зургийг илгээнэ
3. Иргэний үнэмлэхээ барьж авахуулсан сэльфи зургаа оруулна
4. Данс нээх хураамжаа төлж, баталгаажуулна
5. Данс 1-2 хоногт багтан нээгддэг.

Жич: Мэдээлэл дутуу эсвэл буруу бөглөгдсөнөөр данс нээгдэхгүй байх эсвэл онлайн вэб ашиглах боломжгүй болдог.



2. SOCIALPAY АППЛИКЕЙШНЭЭР ДАНСАА НЭЭЛГЭХ

Монгол Улсын насанд хүрсэн иргэн бүр нээлгэх боломжтой.

Данс нээх алхам

1. Гар утсандаа SocialPay аппликейшн суулгана
2. SocialPay аппликейшнийн дээд талын нэмэлт хэсэгт дээр дарна
3. IPO хувьцаа арилжаа хэсэг рүү орно
4. Өөрийн мэдээллээ үнэн зөв бөглөнө
5. Иргэний үнэмлэхний мэдээллээ бөглөнө
6. Данс нээх хураамжаа төлж баталгаажуулна
7. Таны данс 1-2 хоногт нээгдэнэ.

Жич: Мэдээллээ дутуу бөглөсөн тохиолдолд данс автоматаар нээгдэх боломжгүйг анхаарна уу.

SocialPay

Social Pay аппликейшн татах

3. САЛБАР ДЭЭР ДАНС НЭЭЛГЭХ

Насанд хүрээгүй иргэнд данс нээлгэхдээ эцэг эхийн хэн нэг нь хүүхдийн төрсний гэрчилгээ, өөрийн иргэний үнэмлэхтэйгээ ирж данс нээлгэх боломжтой.

ОНЦЛОХ ҮЙЛЧИЛГЭЭ: Q TRANSFER

Харилцагч дотоод болон гадаадын зах зээл дээр хувьцаа арилжсан мөнгөө татаж авахын тулд банк хоорондын шилжүүлэг зэргээс шалтгаалж ажлын 2 буюу түүнээс дээш хоног хүлээдэг. Энэ нь харилцагчид яаралтай санхүүгийн хэрэгцээ үүссэн тохиолдолд багагүй бэрхшээл учруулдаг юм.

Тиймээс бид харилцагчийн хүлээгдэж буй баталгаат орлогод үндэслэн харилцагчийн хүсэлтээр урьдчилан мөнгө олгох харилцагч төвтэй шинэ үйлчилгээг нэвтрүүлээд байна.

FAST PAYMENT

Үйлчилгээний нөхцөл:
Харилцагч гадаад болон дотоодын биржээс татаж буй мөнгөн дүнгээс хамаарч тодорхой хэмжээний шимтгэл төлнө.

ГАДААДЫН ҮНЭТ ЦААСНЫ БРОКЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Голомт Капитал ҮЦК ХХК нь Монгол Улсад анх удаа буюу 2014 онд Хонг Конгт төвтэй гадаад арилжааны брокерын үйлчилгээг, 2019 онд АНУ-д төвтэй Interactive Brokers онлайн брокерийн үйлчилгээг албан ёсны эрхтэйгээр нэвтрүүлсэн билээ.

Ингэснээр харилцагч Interactive Brokers платформоор дамжуулан хүссэн үедээ дэлхийн хөрөнгийн биржүүдийн арилжаанд оролцон хөрөнгө оруулах боломжтой болсон юм.

Тухайлбал, харилцагчид Хонг Конгийн биржид IPO хийж буй компаниудын анхдагч зах зээлийн арилжаанд оролцон хамгийн хямд үнээр хөрөнгө оруулалт хийх боломжтой болсон билээ.

Interactive Brokers

Харилцагч та Interactive Brokers үйлчилгээгээр дамжуулан NYSE, NASDAQ, HKEX, TSX, TSE, LSE, EPA, SWX зэрэг олон улсын хөрөнгийн биржүүдийн арилжаанд оролцон, хувьцаа /анхдагч, хоёрдогч арилжаа/, бонд, үүсмэл үнэт цаас /options, warrant/, ETF /биржээр арилжаалагддаг сан/ гэх мэт төрлийн санхүүгийн төрөл бүрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах боломжтой.

Онлайн брокерийн үйлчилгээ:

- 33 улс
- 135 бирж
- 23 валют
- 600+ хөрөнгө оруулалтын үйлчилгээ авах боломжтой.

Хөрөнгө оруулах боломжтой бүтээгдэхүүн:

- Хувьцаа /анхдагч, хоёрдогч арилжаа/
- Бонд
- Үүсмэл үнэт цаас /option, warrant/
- ETF /биржээр арилжаалагддаг сан/
- Валютын арилжаа

Interactive Brokers нь 1977 онд байгуулагдсан ба дэлхий даяар автоматжуулсан цахим зуучлал, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг. АНУ, Швейцарь, Канад, Хон Конг, Их Британи, Австрали, зэрэг улсуудад салбар төвүүдтэй ба 1850 гаруй ажилтантай, 981 мянга гаруй харилцагчтай.

- 2019 оны шилдэг онлайн брокер
- Олон улсын мэргэжлийн арилжаачид №1 үнэлгээ өгсөн
- Олон улсын идэвхтэй арилжаачид №1 үнэлгээ өгсөн
- Шилдэг хувьцааны арилжааны платформ
- Шилдэг утсанд суурилсан арилжааны платформ

Манай брокерийн үйлчилгээний гол үнэ цэн нь дотоодын болон гадаадын зах зээлээс харилцагчдынхаа хүссэн арилжаа хөрөнгө оруулалтыг түргэн шуурхай гүйцэтгэж, шийдвэр гаргахад нь дэмжлэг болж, чанартай судалгааг хангаж чаддаг явдал юм.

А.Ерболат, Ахлах брокер

АРИЛЖАА, СУДАЛГАА

Э.Мишээл
Форэйкс трэйдэр,
misheel@golomtcapital.com

Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Арилжаа Судалгааны Хэлтэс нь харилцагчийг амжилттай хөрөнгө оруулалт хийж, оновчтой шийдвэр гаргахад нь туслах суурь ба техник шинжилгээг хослуулсан судалгаа, шинжилгээгээр хангаж, шинэ хөрөнгө оруулалтын боломжуудыг санал болгож ажилладаг.

Мөн компанийн өөрийн хөрөнгөөр олон улсын зах зээлд хөрөнгө оруулалт хийх, арилжааны үйл ажиллагааг бие даан эрхлэх, ашиг олох дилерийн үйл ажиллагааг тасралтгүй явуулдаг юм.

Бид өөрсдийн мөнгөн хөрөнгийг өсгөхийн тулд ашигласан мэдээ, мэдээлэл, дунд ба урт хугацааны хөрөнгө оруулалтын судалгааг харилцагчдадаа цаг алдалгүй хүргэдэг. Ингэснээр харилцагч илүү эрсдэл багатай, өгөөжтэй сонголт хийхэд дөхөм болдог билээ.

Бид суурь ба техник шинжилгээг хийхдээ олон улсын түвшний хувьцааны үнэлгээний аргачлалууд болон техник шинжилгээнүүдийг ашигладаг.

Мөн дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн голлох хоёр терминалын нэг болох Блүүмбэргээс хамгийн сүүлийн үеийн мэдээлэл, судалгааг цаг алдалгүй авч өөрсдийн дүгнэлтийг тусган харилцагчдадаа хүргэдэг билээ. Ингэснээр харилцагчдад зөв цагтаа бодит мэдээлэл, судалгааг хүлээн авах боломжийг олгодог юм.

Хөрөнгө оруулалтаас өндөр өгөөж хүртэхийн тулд зөв цагтаа орж, зөв цагтаа гарах нь хамгийн чухал бөгөөд судалгаа шинжилгээ хийж буйн гол зорилго нь энэ үеийг зөв тодорхойлоход оршино.
Э.Мишээл, Форекс трэйдэр

Арилжаа Судалгааны Хэлтэс нь АНУ болон БНХАУ-ын зах зээлд голчлон төвлөрдөг бөгөөд зөвхөн эдгээр улсын зах зээлийг судалдаг тусгай мэргэжилтнийг томилоод байна.

Тодруулбал, БНХАУ-ын стратеги шинжээч нь тус улсын эдийн засгийн бодлого, улс төрийн тогтолцоо, зах зээлийн төлөв байдал зэргийг судалдаг.

Харин Форекс трэйдэр нь олон улсын валютын зах зээлийн судалгаа, арилжааг хөгжүүлэх чиглэлд онцгой анхааран ажиллаж байна.

Манай хэлтсийн судалгааны цар хүрээ нь түүхий эдийн зах зээлийн төлөв байдал, АНУ ба БНХАУ-ын эдийн засаг, хувьцааны анализ, олон улсын валютын зах зээлийн судалгаа болон бондын зах зээлийн анализыг хамардаг бөгөөд цаг хугацааны үечлэлийн хувьд шуурхай мэдээ, өдөр тутмын багц, долоо хоногийн тойм, сарын судалгаа, улирлын төлөв байдал зэрэг давтамжтайгаар харилцагчдадаа хүргэдэг.



Таваарын зах зээлийн долоо хоногийн тойм



Валютын зах зээлийн тойм

Хувьцааны долоо хоногийн тойм мэдээ

Hong Kong IPO

Хятадын банкны хувьцааны анализ

Газрын тосны зах зээл ба тосны Гигантуудын анализ

АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Голомт Капитал ҮЦХ ХХК нь компаниудад үнэт цаас гаргаж, санхүүжилт татах, анхны хөрөнгө оруулалтыг босгоход нь тусладаг андеррайтерийн үйлчилгээг 5 жилийн хугацаанд амжилттай үзүүлж байна.

Бидний үйл ажиллагаандаа баримталдаг гол зарчим нь хөрөнгө оруулагч болон үнэт цаас гаргагч тус бүрийн эрх ашигт нийцсэн шийдлийг олоход оршдог билээ.

М.Мөнхтуяа
Хөрөнгө оруулалтын ахлах шинжээч,
munkhtuya@golomtcapital.com

ХУВЬЦААНЫ САНХҮҮЖИЛТ

Голомт Капитал ҮЦК ХХК нь даатгалын зах зээлд тэргүүлэгч Мандал Даатгал ХК, Хөдөө аж ахуйн цогц шийдлийг хэрэгжүүлэгч Түмэн Шувуут ХК, эрүүл мэндийн хүнсний бүтээгдэхүүний зах зээлд тэргүүлэгч Монос Хүнс ХК-иудын IPO-ны үндсэн андеррайтераар ажилласан.

Мөн уул, уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн ХК-ийн Монголын Хөрөнгийн Бирж дээрх давхар бүртгэлийн хамтрагч андеррайтераар ажилласан юм. Ингэснээр бид нийтдээ 28.6 тэрбум төгрөгийг анхдагч зах зээлээс амжилттай татан төвлөрүүлсэн билээ.

Бид үндэсний үйлдвэрлэгч тэргүүлэгч компаниудын IPO-г хийснээр уг компаниудын засаглал, санхүүгийн удирдлага сайжрах, үйл ажиллагааны ил тод байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлсэн юм. Түүнчлэн Монгол Улсын иргэн бүр Монголын Хөрөнгийн Биржээс уг компаниудын хувьцааг худалдан авах боломж бүрдэж, салбартаа тэргүүлэгч компаниудын хувьцаа эзэмшигч болох боломжтой болсон.

IPO гаргасан компаниуд /2017-2020/

№	Компанийн нэр	IPO хийсэн огноо	Татан төвлөрүүлсэн хөрөнгө /тэрбум төгрөг/	Андеррайтер	Хүлээн авсан захиалгын түвшин
1	Айтүүлс ХК	11/10/2017	1.3	Стандарт Инвестмент ҮЦК	197.2%
2	Анд Энерги ХК	10/30/2017	1.6	Бумбат Алтай ҮЦК	160.0 %
3	Лэндмн ББСБ ХК	3/7/2018	5.0	Мирэ Эссет Секьюритис ҮЦК	779.6 %
4	Монгол Базальт ХК	5/23/2018	6.4	Бумбат Алтай ҮЦК	216.5 %
5	Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК	6/14/2018	2.5	Голомт Капитал ҮЦК, БиДиСек ҮЦК	62.0%
6	Мандал Даатгал ХК	9/18/2018	7.5	Голомт Капитал ҮЦК	22.8%
7	Ард Даатгал ХК	9/26/2018	5.3	БиДиСек ҮЦК	32.7%
8	Түмэн Шувуут ХК	1/31/2019	10	Голомт Капитал ҮЦК	9.1%
9	Ард Кредит ББСБ ХК	3/1/2019	4.9	Ард Капитал ҮЦК	52.9%
10	Монос Хүнс ХК	5/3/2019	8.6	Голомт Капитал ҮЦК	22.3%
11	Инвескор ББСБ ХК	5/30/2019	17.6	ТиДиБи Капитал ҮЦК	7.5%
12	Бодь Даатгал ХК	6/8/2020	5.3	БиДиСек ҮЦК	0.3%
13	Үндэсний хувьчлалын сан хамтын хөрөнгө оруулалтын сан	10/16/2020	4.8	Ард Менежмент ҮЦК	16.6%

БОНДЫН САНХҮҮЖИЛТ

Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Андеррайтерийн хэлтэс нь өнгөрсөн 5 жилийн хугацаанд нийт 17 компанийн хаалттай болон нээлттэй бондын андеррайтераар ажиллаж, нийт 19.3 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүллээ.

Бид **МОНГОЛЫН АНХНЫ БӨГӨӨД ХАМГИЙН ӨНДӨР ДҮНТЭЙ НЭЭЛТТЭЙ БОНД** болох Сүү ХК-ийн 6 тэрбум төгрөгийн нээлттэй бондыг босгосон төдийгүй Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг тодорхойлох анхдагч бондын бүтээгдэхүүнүүдийг амжилттай нэвтрүүлсэн билээ.

Үүнээс дурдвал:

МОНГОЛЫН АНХНЫ ДААТГАГДСАН БОНД

ERCHIM ENGINEERING LLC	**ЭРЧИМ Бонд 2015 он**	**500 сая төгрөг**

МОНГОЛЫН АНХНЫ ХАЙБРИД БОНД

Master Tunshlel	**Hybrid Bond 2020 он**	**3.8 тэрбум төгрөг**

МОНГОЛЫН АНХНЫ 100% БАНКНЫ БАТАЛГААТ БОНД

numur Банк бус санхүүгийн байгууллага	**НӨМӨР Бонд 2020 он**	**1.0 тэрбум төгрөг**

CYY Бонд
2017 он
6 тэрбум төгрөг

УРБАН Бонд
2017, 2018 он
2.1 тэрбум төгрөг

ММФ Бонд
2015, 2017 он
1.2 тэрбум төгрөг

НЕТ Бонд
2018 он
1.0 тэрбум төгрөг

БЭРС Бонд
2018 он
900 сая төгрөг

АЛТАН НАМАР Бонд
2018 он
400 сая төгрөг

Ти Жэй Эн Ресайклинг ХХК

Бонд
2019 он
120 сая төгрөг

Би Жи Эл Прогресс ХХК

Бонд
2019 он
2.0 тэрбум төгрөг

Эко Плант Трейд ХХК

Бонд
2019 он
279 сая төгрөг

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Андеррайтерийн Хэлтэс нь дотоодын компаниудад стратегийн томоохон бодлого, шийдвэр, хэлцэл, M&A буюу компани хоорондын нэгдэлтэй холбоотой хөрөнгө оруулалтын бүх төрлийн зөвлөх үйлчилгээг өөрсдийн мэдлэг, туршлага дээр үндэслэн үзүүлж байна. Үүнд:

1. Компанид хаалттай болон нээлттэй хүрээнд санхүүжилт татах зөвлөх үйлчилгээ
2. Компанийн үнэлгээ тогтоох үйлчилгээ
3. Бизнес төлөвлөгөө бичих үйлчилгээ
4. Хувь хүний хөрөнгийн удирдлагын үйлчилгээ
5. Хувьцааны зөвлөх үйлчилгээ
6. Хуулийн зөвлөх үйлчилгээ
7. Маркетингийн зөвлөх үйлчилгээ
8. Санхүү бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ тус тус багтаж байна.

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нөлөөлдөг хамгийн чухал хүчин зүйл бол түргэн шуурхай бөгөөд бодит мэдээлэл юм. Иймд Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Андеррайтерийн Хэлтэс нь дотоодын эдийн засаг, хөрөнгийн зах зээлд тохиосон голлох үйл явдлын мэдээ, мэдээлэл, судалгаа шинжилгээг өдөр тутам болон долоо хоног бүр тогтмол хүргэж байна.

Мөн дотоодын хувьцаат компаниудын санхүүгийн шинжилгээ, зах зээлийн үзүүлэлтийг тогтмол шинэчлэн хүргэж, харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд зориулсан мэдээллийг хүргэдэг.

Ялангуяа харилцагчийг хөрөнгө оруулалтын зөв шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор бид дотоодын хувьцааны дэлгэрэнгүй судалгаа, шинжилгээг хүргэж эхэлсэн билээ.

Эдүгээ бид АПУ ХК, Монос Хүнс ХК, Түмэн Шувуут, Мандал Даатгал ХК-иудын хувьцааны судалгаа, шинжилгээг харилцагчдадаа танилцуулаад байна.

Цаашид харилцагчийн хөрөнгө оруулалтын шийдвэрт бодитой хувь нэмэр оруулахуйц дотоодын санхүүгийн зах зээл болон эдийн засагт өрнөж буй бүхий л мэдээ, мэдээлэл, судалгаа, шинжилгээг түргэн шуурхай, тогтмол хүргэн ажиллах болно.

МӨНӨС
Хувьцааны
Анализ
2020
12.22
MFC:MO
Хаалтын ханш
Зорилтот ханш:
Өсөх боломж:
Golomt Capital

ТҮМЭН ШУДУУТ
Хувьцааны
Анализ
MSE:
Хаалтын ханш:
Бодит ханш:
Өсөх боломж:
Golomt Capital


MANDAL
Хувьцааны
Анализ
MSE:
Хаалтын ханш:
Бодит ханш:
Өсөх боломж:
Golomt Capital

Golomt Capital
Дотоодын зах зээл
Долоо хоногийн тойм

GCC АКАДЕМИ

Монголын хөрөнгийн зах зээлд шинэ соёлыг түгээхээр зорин ажилладаг Голомт Капитал ҮЦК ХХК-ийн хамт олон хөрөнгийн зах зээлийн талаарх цогц мэдлэг, мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор GCC академийг үүсгэн байгуулаад байна.

GCC нь Golomt Capital Coach гэсэн үгний эхний үсгүүдийн товчлол бөгөөд хүссэн хүн бүрт хөрөнгийн зах зээлийн талаарх суурь мэдлэгийг олгож, шилдэг хөрөнгө оруулагчдыг бэлтгэх, хөгжүүлэх, дасгалжуулах замаар монголын төдийгүй дэлхийн хөрөнгийн зах зээлээс өндөр өгөөж хүртэх боломжийг нээх зорилготой юм.

Тус академийн сургагч багш нар нь **Голомт Капитал ҮЦК ХХК**-ийн үндсэн үйл ажиллагаа болох брокер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг дотоод гадаадын харилцагч түншүүддээ үзүүлж ирсэн, олон жилийн дадлага туршлагатай, өндөр мэдлэг боловсролтой, салбартаа үнэлэгдсэн мэргэжлийн баг хамт олон юм. Мөн монголын төдийгүй дэлхийн эдийн засаг, салбарын зах зээлийн судалгааг тогтмол амжилттай гүйцэтгэж ирснээрээ давуу талтай билээ.

GCC академи нь анхан, дунд, ахисан гэсэн 3 түвшний сургалтыг байгууллага, хувь хүний захиалгаар танхимын болон онлайн байдлаар зохион байгуулж буйгаараа онцлогтой юм.

Хувьцаа,
бондын сургалт



Санхүүгийн зах зээлийн
хууль, эрх зүйн мэдээлэл

Харилцагчийн
цаг

Weekly Debate
by Golomt Capital



Hong Kong
IPO

Онцлох үйл явдлын
мэдээ, мэдээлэл

Golomt Capital golomt_capital GolomtCapital

Г.Мөнх-Эрдэнэ
Дэд захирал
9480-3111

АНДЕРРАЙТЕРИЙН ХЭЛТЭС

М.Мөнхтуяа
Хөрөнгө оруулалтын ахлах шинжээч
9973-7911

Б.Тэлмэн
Хөрөнгө оруулалтын шинжээч
9585-2121

Б.Дөлгөөн-Од
Хөрөнгө оруулалтын шинжээч
9944-8080

АРИЛЖАА, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

Э.Мишээл
Форэкс трэйдэр
8810-5535

Т.Азтүшиг
Стратеги шинжээч
9997-0303

М.Чинсанаа
Куант Аналист
88181888

БРОКЕРИЙН ХЭЛТЭС

А.Ерболат
Ахлах брокер
8006-9977

Н.Гомбодорж
Брокер
8002-6600

А.Гэрэлмаа
Брокер
8003-7272

Н.Энхмандах
Клерк
8004-3838



С.Ариунжаргал
Клерк
8004-6611

info@golomtcapital.com
7012-1530